



ЭДИЙН ЗАСАГ,
ХӨГЖЛИЙН ЯАМ

МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТАНИЛЦУУЛГА

2024 оны III улирал



Энэхүү тайланд тусгагдсан үр дүн, тайлбар, дүгнэлт нь Эдийн засаг, хөгжлийн яамны байр суурийг илэрхийлэх албагүй болно.

Уг тайланг арилжааны бус зорилгоор бүрэн болон хэсэгчилсэн байдлаар ашиглаж болох бөгөөд ашигласан тохиолдолд “Макро эдийн засгийн танилцуулга, 2024 оны 3 дугаар улирал, Эдийн засаг, хөгжлийн яам” хэмээн эх сурвалж хэсэгт тодотгоно уу.
Санал хүсэлт болон өөр бусад мэдээллийн талаар асууж тодруулах бол MEPD@med.gov.mn цахим шуудан эсвэл дараах хаягаар хандана уу.

Эдийн засаг, хөгжлийн яам, Чингэлтэй дүүрэг, Ж.Самбуугийн гудамж, Засгийн газрын XI байр, Улаанбаатар хот 15141, Монгол Улс



МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТАНИЛЦУУЛГА

2024 ОНЫ III УЛИРАЛ

Агуулга

ХУРААНГУЙ ДҮГНЭЛТ.....	5
БОГИНО ХУГАЦААНЫ ТӨЛӨВ.....	6
1. БОДИТ СЕКТОР	7
1.1. Нийт нийлүүлэлт	9
1.2. Нийт эрэлт.....	14
1.3. Хөдөлмөр ба аж ахуйн нэгж.....	16
1.4. Эдийн засгийн мөчлөг.....	21
2. ТӨСВИЙН СЕКТОР	22
2.1. Төсвийн гүйцэтгэл	24
2.2. Төсвийн бодлогын төлөв.....	27
2.3. Засгийн газрын өрийн тогтвортой байдал	28
3. МӨНГӨНИЙ СЕКТОР.....	30
3.1. Инфляц.....	32
3.2. Мөнгө ба санхүүгийн салбар.....	35
4. ГАДААД СЕКТОР.....	38
4.1. Гадаад худалдаа.....	40
4.2. Төлбөрийн тэнцэл.....	43
4.3. Гадаад өр	45
5. ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСАГ.....	48
5.1. Дэлхийн эдийн засгийн нөхцөл байдал	50
5.2. Түүхий эдийн зах зээлийн хандлага	51
5.3. Олон улсад 2024 онд зарлагдсан индексүүд.....	52
6. ЭРСДЭЛ	55
Хавсралт	57

Зураг, хүснэгт, шигтгээний жагсаалт

Зураг 1.1. Бодит ДНБ-ий өсөлт.....	9
Зураг 1.2. Хүлэмжийн хийн ялгарал	11
Зураг 1.3. Нүүрсхүчлийн хийн татварын өрхийн зардалд үзүүлэх нөлөө	12
Зураг 1.4. Нүүрсхүчлийн хийн татварын орлогын хуваарилалт	14
Зураг 1.5. Өсөлтийн бүтэц (эрэлт талаас)	14
Зураг 1.6. Хөдөлмөрийн зах зээл	16
Зураг 1.7. Улсын дундаж болон голч цалин, хөдөлмөрийн зах зээлд зарлагдсан ажлын байрны цалин	17
Зураг 1.8. Аж ахуйн нэгж	19
Зураг 1.9. Хэрэглэгчийн итгэлийн индекс, улирлаар	20
Зураг 1.10. Үйлдвэрлэлийн зөрүү	21
Зураг 2.1. Төсвийн орлого.....	24
Зураг 2.2. Төсвийн зарлага	25
Зураг 2.3. Төсвийн тэнцэл, төсвийн төлөв, автомат тогтворжуулагч	27
Зураг 2.4. Засгийн газрын өр	28
Зураг 2.5. Засгийн газрын өрийн тогтвортой байдал.....	29
Зураг 3.1. Инфляцын бүрэлдэхүүн.....	32
Зураг 3.2. Тэйлорын хүү, мөнгөний нөхцөлийн индекс	33
Зураг 3.3. Голлох бүтээгдэхүүний үнэ	34
Зураг 3.4. Мөнгөний нийлүүлэлт, зээлийн үзүүлэлтүүд	35
Зураг 3.5. Зээлийн жилийн өсөлтийн бүрэлдэхүүн, хүүгийн үзүүлэлтүүд.....	36
Зураг 4.1. Экспорт.....	40
Зураг 4.2. Импорт.....	42
Зураг 4.3. Урсгал дансны тэнцэл, гадаад валютын нөөц, төгрөгийн ханш	43
Зураг 4.4. Урсгал данс ба гадаад хөрөнгө оруулалтын цэвэр позиц	44
Зураг 4.5. Гадаад өр	45
Зураг 4.6. Гадаад өрийн тогтвортой байдал.....	47
Зураг 5.1. Дэлхийн эдийн засаг	50
Зураг 5.2. Түүхий эдийн олон улсын зах зээл дэх үнэ	51
Зураг 5.3. Инфляцын жилийн дундаж түвшин, Монгол Улс.....	53
Хүснэгт 1. Үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжийн тооны өөрчлөлт, ажиллагчдын тоогоор	18
Хүснэгт 2. Хэрэглэгчийн итгэлийн индексийн бүрэлдэхүүн	20
Хүснэгт 3. Дэлхийн засаглалын үзүүлэлтийн Монгол Улсын оноо, эрэмбэ.....	52
Хүснэгт 4. Дэлхийн эдийн засгийн эрх чөлөөт байдлын индексийн Монгол Улсын оноо, эрэмбэ	53
Хүснэгт 5. Макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд.....	58
Хүснэгт 6. Бодит секторын үзүүлэлтүүд.....	59
Хүснэгт 7. Нэгдсэн төсвийн үзүүлэлтүүд.....	60
Хүснэгт 8. Нэгдсэн төсвийн үзүүлэлтүүд (ДНБ-д эзлэх хувиар)	61
Хүснэгт 9. Төлбөрийн тэнцлийн үзүүлэлтүүд	62
Хүснэгт 10. Төлбөрийн тэнцлийн үзүүлэлтүүд (ДНБ-д эзлэх хувиар)	63
Хүснэгт 11. Мөнгөний үзүүлэлтүүд.....	64
Шигтгээ 1. Нүүрстөрөгчийн татварын эдийн засагт үзүүлэх нөлөө	11
Шигтгээ 2. Хэрэглэгчийн итгэлийн индекс	20

ТОВЧИЛСОН ҮГ

ААН	Аж ахуйн нэгж
ААНОАТ	Аж, ахуйн нэгжийн орлогын албан татвар
АМНАТ	Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
ОХУ	Оросын Холбооны Улс
ХБНГУ	Холбооны Бүгд Найрамдах Герман Улс
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ЭЗХЯ	Эдийн засаг, хөгжлийн яам
ХИИ	Хэрэглэгчийн итгэлийн индекс

ХУРААНГУЙ ДҮГНЭЛТ

Уул уурхай, худалдаа, үйлчилгээний салбаруудын идэвхжил эдийн засгийн өсөлтийг голлон дэмжлээ.

Уул уурхайн салбарт нүүрс, төмрийн хүдэр, зэсийн баяжмалын олборлолт нэмэгдэж, худалдаа, үйлчилгээний салбарын өсөлт өндөр хадгалагдсанаар Монгол Улсын эдийн засаг 2024 оны эхний 3 улиралд 5.0 хувиар өслөө. Харин цаг агаарын тааламжгүй нөхцөл байдлаас шалтгаалсан хөдөө аж ахуйн салбарын агшилт эдийн засгийн өсөлтөд сөрөг нөлөө үзүүлсэн хэвээр байна. Хөдөлмөр эрхлэлт нэмэгдэж, уул уурхайн машин механизмын хуримтлал өссөнөөр нийт эдийн засгийн потенциал үйлдвэрлэлийн өсөлт 4 орчим хувьд хүрч нэмэгдэн, уул уурхайн болон уул уурхайн бус үйлдвэрлэлийн сөрөг зөрүү хаагдлаа.

Эрэлт талаас хэрэглээ, хөрөнгө оруулалт эдийн засгийн өсөлтөд голлон нөлөөллөө. Цалин, тэтгэвэр, тэтгэмжийн өсөлт өрхийн бодит орлогыг дэмжиж, өрхийн хэрэглээ тэлсэн бол төсвийн урсгал зардлын өсөлтийн нөлөөгөөр төрийн хэрэглээ өсөж, дотоод эрэлтийн өсөлт хадгалагдлаа. Мөн машин тоног төхөөрөмжийн нөөц нэмэгдэж, эдийн засаг дах үндсэн хөрөнгийн хуримтлал өслөө. Нөгөө талаас эдийн засгийн идэвхжилийг дагасан хөрөнгө оруулалтын болон хэрэглээний бүтээгдэхүүний импорт өсөлт өндөр байв.

Инфляц зорилтот түвшинд хадгалагдлаа. Инфляц 2024 оны 9 дүгээр сард 6.7 хувьд хүрч, төв банкны зорилтот түвшинд хадгалагдав. Импортын бараа, бүтээгдэхүүний инфляц тогтвортой байсан бол дотоодын бараа, үйлчилгээний инфляц өсөх хандлагатай байлаа. Эдийн засгийн идэвхжил хадгалагдсанаар эрэлтийн гаралтай инфляц өссөн бол махны үнэ өмнөх онуудын хандлагаас өндрөөр өссөн нь нийлүүлэлтийн гаралтай инфляц нэмэгдэхэд нөлөөллөө. Төв банк энэ онд бодлогын хүүг нийт 3 нэгж хувиар буурууллаа. Арилжааны банкнуудын зээлийн өсөлт сүүлийн 10 жилийн дээд түвшинд хүрч эрчимжиж, мөнгөний нийлүүлэлтийн өсөлтөд голлох нөлөө үзүүллээ.

Төсвийн нийт тэнцэл 2024 оны эхний 3 улирлын байдлаар 2.5 их наяд төгрөгийн ашигтай гарлаа.

Хэдийгээр нүүрсний үнийн бууралт АМНАТ-ийн орлогод сөргөөр нөлөөлсөн ч орлогын албан татвар болон нэмэгдэл өртгийн албан татварын орлогын голлох нөлөөгөөр төсвийн орлого энэ оны эхний 3 улирлын байдлаар 28.9 хувиар өсөж, орлого бүрдүүлэлт сайн байв. Төсвийн зарлага өмнөх оноос 34.4 хувиар нэмэгдэхэд төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг хангах, орон нутагт ажиллах нөхцөлийг сайжруулах зорилгоор орон нутгийн албан хаагчдын цалинг нэмэгдүүлсэн нь голлон нөлөөллөө. Засгийн газрын нэрлэсэн дүнгээр илэрхийлсэн өрийн үлдэгдлийн ДНБ-д харьцуулсан харьцаа 2024 оны 3 дугаар улирлын байдлаар 38.9 хувьд хүрч нэмэгдсэн ч нийслэлийн гадаад болон дотоод зах зээлд гаргасан үнэт цаастай холбоотойгоор дунд хугацаанд Засгийн газрын өрийн хэмжээ нэмэгдэхээр байна.

Импортын өсөлтийн нөлөөгөөр урсгал дансны алдагдал нэмэгдлээ. Экспортын орлого өмнөх оны мөн үеэс 4.3 хувиар өссөн ч импортын өсөлт 27.4 хувьд хүрснээр урсгал дансны алдагдал тэллээ. Гэсэн хэдий ч импортын өсөлтийн дийлэнхийг үйлдвэрлэлийн завсрын хэрэглээнд ашиглагддаг, хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн бүрдүүлж байгаа нь цаашид эдийн засгийн хүчин чадлыг нэмэгдүүлж, ирэх онуудын эдийн засгийн өсөлтийг дэмжихээр байна. Гадаад валютын эрэлт өссөнөөр 2024 оны 3 дугаар улиралд гадаад валютын нөөцийн жилийн өсөлт саарч, төгрөгийн нэрлэсэн ханшийн индекс суларлаа.

Монгол Улс эдийн засгийн тогтвортой байдлыг амжилттай хадгалж, зээлжих зэрэглэлийг ахиуллаа.

Сүүлийн жилүүдэд цар тахал, геополитикийн тогтворгүй байдлаас үүдэлтэй дэлхий нийтийг хамарсан инфляцын өсөлт, төв банкнуудын мөнгөний хатуу бодлого зэрэг амаргүй нөхцөл байдалтай нүүр тулсан хэдий ч Монгол Улс эдийн засгийн тогтвортой байдлыг хангахад чиглэсэн бодлогын арга хэмжээнүүдийг амжилттай хэрэгжүүлсний үр дүнд зээлжих зэрэглэлээ ахиуллаа. Эдийн засгийн идэвхжил хадгалагдаж, экспортын сэргэлтийн нөлөөгөөр гадаад валютын нөөц нэмэгдсэн, дунд хугацааны гадаад өрийн дарамт буурсан зэрэг макро эдийн засгийн эерэг үзүүлэлтүүд болон цаашдын эерэг төлөвийг харгалзан Монгол Улсын зээлжих зэрэглэлийг “Fitch Ratings” агентлаг “B+, тогтвортой”, “S&P Global Ratings” агентлаг “B+, эерэг”, “Moody’s” агентлаг “B2, тогтвортой” болгон тус тус сайжрууллаа.

БОГИНО ХУГАЦААНЫ ТӨЛӨВ

Эдийн засгийн өсөлт 2025 онд 8.0 хувь орчимд хадгалагдах төлөвтэй байна.

Нүүрс, төмрийн хүдэр, зэсийн баяжмал зэрэг уул уурхайн голлох бүтээгдэхүүнүүдийн үйлдвэрлэл нэмэгдэж, уул уурхайн салбарын өсөлтийг дэмжихээр байна. Энэ онд эдийн засгийн үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлэх тоног төхөөрөмж, машин механизмын импортын өсөлт өндөр байсан нь цаашид эдийн засгийн потенциалыг нэмэгдүүлж, өсөлтийг дэмжихээр байна. Тухайлбал, уул уурхайн салбарт ашиглагддаг хүнд машин механизмуудын импорт өмнөх оноос 2 дахин, ачааны тээврийн хэрэгсэл 85 хувиар тус тус өссөн зэрэг нөлөөгөөр 2025 онд уул уурхай болон тээврийн салбарын өсөлт өндөр байхаар байна.

Мөн эрчим хүчний салбарт хэрэгжиж буй Бөөрөлжүүт, Чойбалсангийн станц, Багануурын батареи хуримтлуурын бүтээн байгуулалтууд нийт эдийн засгийн потенциал хүчин чадлыг дэмжинэ. Түүнчлэн, сүүлийн 7 улирал дараалан агшаад буй хөдөө аж ахуйн салбар ирэх оноос сэргэж, эдийн засгийн өсөлтийг дэмжиж эхэлнэ гэж тооцож байна. Хүнс, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн зориулалттай тоног төхөөрөмжийг гаалийн татвараас хөнгөлсний үр дүнд хүнсний үйлдвэрлэлийн зориулалттай тоног төхөөрөмжийн импорт энэ онд өссөний зэрэгцээ хөдөө аж ахуйн салбар сэргэхээр байгаа нь цаашид

боловсруулах салбарын өсөлтийг дэмжихээр байна. Мөн эдийн засгийн дотоод эрэлтийн идэвхжил хадгалагдаж, худалдаа, үйлчилгээний салбарын өсөлтийг дэмжихээр байна.

Нүүрс болон зэсийн баяжмалын экспорт 2024 онд төлөвлөсөн хэмжээг давахаар байгаа бөгөөд Монгол Улс 2025 онд 83 сая тонн нүүрс, 1,780 мянган тонн зэсийн баяжмал экспортлохоор зорьж байна. Гэсэн хэдий ч дэлхийн эдийн засаг, геополитикийн тодорхой бус байдлаас шалтгаалсан экспортын голлох бүтээгдэхүүнүүдийн үнийн тогтворгүй байдал манай улсын экспортын орлогод сөргөөр нөлөөлж болзошгүй байна.

Инфляц 2025 онд төв банкны зорилтот түвшний дээд хязгаарт хүрэх төлөвтэй байна.

Инфляц 2025 онд төв банкны зорилтот түвшний дээд хязгаар орчимд, дунджаар 7.2 хувь байх хүлээлттэй байна. Хөдөө аж ахуйн салбарын агшилтаас үүдэлтэйгээр махны нийлүүлэлт буурч, махны үнэ улирлын хандлагаасаа өндрөөр өсөх, эрчим хүчний тарифын нэмэгдлийн нөлөөгөөр дотоодын бараа, үйлчилгээний инфляц өсөх төлөвтэй байна. Мөн геополитикийн тогтворгүй байдал, уур амьсгалын өөрчлөлт, тээвэр логистикийн саатлаас үүдэн импортын инфляц нэмэгдэх эрсдэлүүд хэвээр байна.

БҮЛЭГ 1

БОДИТ СЕКТОР

- 1.1 Нийт нийлүүлэлт
- 1.2 Нийт эрэлт
- 1.3 Хөдөлмөр ба бизнес
- 1.4 Эдийн засгийн мөчлөг

1. БОДИТ СЕКТОР

ТОЙМ

Уул уурхайн салбарын үйлдвэрлэл өсөж, худалдаа, үйлчилгээний салбарын идэвхжил нэмэгдсэн нь эдийн засгийн өсөлтийг голлон дэмжлээ. Эрэлт талаас хөдөлмөр эрхлэлт нэмэгдэн, өрхийн бодит орлого сайжирч, хэрэглээ тэлсэн нь өсөлтийг дэмжсэн бол эдийн засгийн идэвхжилийг дагасан хэрэглээ, хөрөнгө оруулалтын импорт өссөн нь өсөлтөд сөргөөр нөлөөлөв. Уул уурхайн тоног төхөөрөмжийн хуримтлал өсөж, хөдөлмөр эрхлэлт нэмэгдсэн нь эдийн засгийн потенциалыг нэмэгдүүллээ.

НИЙТ НИЙЛҮҮЛЭЛТ

1. Эдийн засгийн өсөлтөд уул уурхай, үйлчилгээний салбарууд голлон нөлөөллөө.

Нэрлэсэн ДНБ 2024 оны эхний 3 улирлын байдлаар 56 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 19 хувиар, бодит дүнгээр өмнөх оны мөн үеэс 5.0 хувиар тус тус өслөө. Уул уурхай болон үйлчилгээний салбарууд нийт эдийн засгийн өсөлтийн 6.0 нэгж хувийг бүрдүүлсэн бол хөдөө аж ахуйн салбарын уналт үргэлжилж, эдийн засгийн өсөлтийг хязгаарласан хэвээр байна.

2. Нүүрс, төмрийн хүдэр, зэсийн баяжмалын олборлолт нэмэгдсэн ч 2023 оны өндөр суурийн нөлөөгөөр уул уурхайн өсөлтийн хурд саарлаа.


Өмнөх оны эхний 3 улиралд 32.7 хувиар өсөж байсан уул уурхайн салбар энэ оны эхний 3 улиралд 11.4 хувиар өсөж, өсөлтийн хурд саарлаа. Тухайлбал, өмнөх оны өндөр түвшинтэй харьцуулахад нүүрс олборлолт 28 хувиар өсөж 72.2 сая тоннд, төмрийн хүдрийн олборлолт 30 хувиар өсөж 7.2 сая тоннд хүрч нэмэгдсэн нь салбарын

өсөлтөд голлон нөлөөлөв. Мөн Оюутолгойн гүний уурхайн олборлолт 3 дугаар улиралд эрчимжсэнтэй холбоотойгоор нийт зэсийн баяжмалын үйлдвэрлэл 1,104 мянган тоннд хүрч 5.1 хувиар өссөн байна. Харин газрын тос, алт олборлолт харгалзан 13 болон 12 хувиар тус тус буурлаа. Цаашид нүүрс, төмрийн хүдэр, зэсийн баяжмалын үйлдвэрлэл уул уурхайн салбарын өсөлтийн төлөвт эергээр нөлөөлөхөөр байна.

3. Үйлчилгээний салбарын өсөлт эрчимжин уул уурхайн бус салбар нийт эдийн засгийн өсөлтийн гуравны хоёрыг бүрдүүллээ.

Уул уурхайн бус салбар 2024 оны эхний 3 улиралд 4.0 хувиар тэллээ. Тухайлбал, худалдаа, тээвэр, мэдээлэл холбоо болон үйлчилгээний бусад салбаруудын гүйцэтгэл энэ оны 3 дугаар улиралд сайн байж өсөлтийг дэмжсэн бол барилга болон боловсруулах салбарын үйлдвэрлэлийн өсөлт саарч, хөдөө аж ахуйн салбарын уналт үргэлжилж байна. Тэвэрээс бусад үйлчилгээний салбарууд буюу бөөний

Зураг 1.1 Бодит ДНБ-ий өсөлт



болон жижиглэн худалдаа, мэдээлэл, холбоо болон үйлчилгээний бусад салбаруудын өсөлт эрчимжиж, 2024 оны эхний 3 улиралд 8.8 хувиар тэлж, эдийн засгийн өсөлтийг 3.7 нэгж хувиар нэмэгдүүллээ. Иргэдийн худалдан авалтын идэвх нэмэгдсэнээр бөөний болон жижиглэн худалдааны салбар оны эхний 3 улиралд 7.9 хувийн өсөлттэй байна. Тус салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжийн тоо өсөж, хөдөлмөр эрхлэлт нэмэгдсэн, мөн шинээр олгосон зээл худалдааны салбарт хамгийн ихээр нэмэгдсэн нь салбарын үйл ажиллагаа сайжирч байгааг илтгэж байна. Тухайлбал, худалдааны салбарт 2024 оны эхний 3 улиралд 14,810 аж ахуйн нэгж шинээр нэмэгдэж, үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжийн тоо 6 хувиар өссөн бөгөөд шинээр олгосон зээл өмнөх оны мөн үетэй харьцуулахад 34 хувиар нэмэгджээ. Түүнчлэн мэдээлэл, холбооны салбар 14.4 хувиар, үйлчилгээний бусад салбарууд 8.6 хувиар тус тус тэлсэн байна. Цаашид үйлчилгээний салбарын өсөлт хадгалагдаж, эдийн засгийн өсөлтийг дэмжсэн хэвээр байхаар байна.

4. Худалдаа эргэлт нэмэгдэхийн хэрээр тээврийн салбар өсөж байна. Ачаа тээвэр 2024 оны эхний 3 улиралд 87.5 сая тоннд хүрч, өмнөх оны мөн үеэс 21 хувиар нэмэгдсэн бөгөөд нийт тээвэрлэсэн ачааны 86 хувь буюу 75.0 сая тонн ачааг уул уурхайн бүтээгдэхүүн бүрдүүллээ. Уул уурхайн бүтээгдэхүүн, ялангуяа нүүрсний экспортын биет хэмжээ өмнөх оны мөн үеэс 25 хувиар нэмэгдсэний зэрэгцээ төмөр замын тээврийн орох урсгал (бараа бүтээгдэхүүний импорт) болон дамжин өнгөрөх тээвэр өмнөх оны мөн үеэс 6.8 болон 7.8 хувиар тус тус нэмэгдсэн нөлөөгөөр тээврийн салбарын үйлдвэрлэл 16 хувиар нэмэгдэж, эдийн засгийн өсөлтийг 0.9 нэгж хувиар дэмжлээ.

5. Боловсруулах салбарын өсөлтийг бүх төрлийн ундаа болон химийн бодис үйлдвэрлэл дэмжиж байна. Боловсруулах салбар 2024 оны эхний 3 улиралд өмнөх оны мөн үеийн түвшинд буюу 0.1 хувиар өсөв. Тус салбарын 20-25 орчим хувийг бүрдүүлдэг бүх төрлийн ундааны үйлдвэрлэл 10 хувиар өсөж, боловсруулах салбарын өсөлтийг тэтгэв. Тухайлбал ус болон хийжүүлсэн ундаа үйлдвэрлэл 7 хувиар, согтууруулах ундаа 35 хувиар, жүүс 40 хувиар тус тус өссөн байна. Мөн уул уурхайн салбарын эрчимжилтийг даган тэсэлгээний

зориулалттай химийн бодис үйлдвэрлэл нэмэгдэж, боловсруулах салбарын өсөлтийг дэмжлээ. Харин мал хорогдлын нөлөөгөөр боловсруулах салбарын 15 орчим хувийг бүрдүүлдэг мах болон нэхмэл эдлэлийн үйлдвэрлэл буурсан нь тус салбарын өсөлтийг хязгаарлалаа.

6. Нийслэлд хэрэгжсэн инженерийн барилга байгууламжийн бүтээн байгуулалтын нөлөөгөөр барилгын салбар өслөө. Барилгын салбар 2024 оны эхний 3 улиралд 7.8 хувиар өссөн нь төсөөлөлтэй нийцтэй байна. Салбарын өсөлтөд Улаанбаатар хотын авто зам, гүүр, гүүрэн гарц, далан, суваг, шугам сүлжээний бүтээн байгуулалтын ажил голлож байна. Мөн худалдаа, үйлчилгээний барилга байгууламж болон Өмнөговь, Ховд аймгийн автозамын бүтээн байгуулалтууд салбарын өсөлтөд эергээр нөлөөллөө.

7. Эрчим хүч, усан хангамж тогтвортой байна. Эрчим хүчний үйлдвэрлэл 2024 оны эхний 3 улиралд 6,186 сая кВт.ц болж, өмнөх оны мөн үеэс 5.1 хувиар өссөн бол түгээсэн цэвэр ус өмнөх оны мөн үеэс 4.2 хувиар өсөж 52.5 сая м³ хүрлээ. Цахилгаан эрчим хүчний үйлдвэрлэл нь эдийн засгийн бусад салбаруудын завсрын хэрэглээнд ашиглагддаг, үйлдвэрлэл тогтвортой явагдахад чухал нөлөөтэй учир цаашид эрчим хүчний салбарт либералчлалыг үргэлжлүүлж, хөрөнгө оруулалт татах, эх үүсвэрийн хүчин чадлыг нэмэгдүүлж, эрчим хүчний салбарын өсөлтийг тогтвортой бөгөөд өндөр түвшинд хадгалах шаардлагатай.

8. Улаан буудай тариалсан талбай буурсан нь хөдөө аж ахуйн салбарт сөргөөр нөлөөллөө. Хөдөө аж ахуйн салбарын 90 орчим хувийг мал аж ахуй, 10 орчим хувийг газар тариалангийн салбар бүрдүүлдэг бөгөөд улирлын онцлогоор жил бүрийн 3 дугаар улиралд газар тариалангийн салбарын хөдөө аж ахуйн салбарт үзүүлэх нөлөө нэмэгддэг. Мал аж ахуйн салбарт 2024 оны эхний 3 улирлын байдлаар том малын зүй бус хорогдол 8.1 сая толгойд хүрч, өмнөх улирлаас 43 мянган толгой малаар нэмэгдлээ. Мөн энэ онд нийт тариалсан талбайн 60 орчим хувийг бүрдүүлдэг улаан буудайн тариалсан талбай 5.3 хувиар буурснаар хураасан ургацын хэмжээ өмнөх оноос буурч, хөдөө аж ахуйн салбарын эдийн засаг дах сөрөг нөлөө хадгалагдлаа.

¹ Цахилгаан эрчим хүч болон сэргээгдэх эрчим хүчний нийлбэр

ШИГТГЭЭ 1. НҮҮРСТӨРӨГЧИЙН ТАТВАРЫН ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨ

ХҮЛЭМЖИЙН ХИЙН ЯЛГАРЛЫН ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ, ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ


Дэлхий даяар хүлэмжийн хийн ялгарал нэмэгдэж, түүнээс шалтгаалсан уур амьсгалын хурдтай өөрчлөлтийг сааруулах асуудал улам чухал болсоор байна. Дэлхийн агаарын дундаж температур сүүлийн 100 жилд 1.1 хэмээр, Монгол орны хувьд 2.2 хэмээр нэмэгдэж, цаг уурын эрс тэс үзэгдлийн давтамж өссөөр байна.

Монгол Улс дэлхийн нийт хүлэмжийн хийн ялгарлын зөвхөн 0.12 хувийг бүрдүүлдэг боловч нэг хүнд ногдох хүлэмжийн хийн ялгарлын хэмжээгээр 9 дүгээрт жагсаж байна (Дэлхийн банк, 2024). Монгол Улс 2006 он хүртэл хүлэмжийн хийн ялгарлыг цэвэр дүнгээр шингээгч улс байсан бол 2007 оноос хүлэмжийн хийн ялгарал шингээх түвшнийг тогтмол давж, 2020 онд нийт 43.1 сая тонн CO₂-той дүйцэхүйц хэмжээний хийг ялгаруулжээ (Зураг 1.2). Уг ялгарлыг эх үүсвэрээр харвал, нийт хүлэмжийн хийн ялгарлын 97 хувь нь хөдөө аж ахуй болон эрчим хүчний салбараас үүдэлтэй бөгөөд энэ нь уламжлалт мал аж ахуйн хэв маяг, малын тоо толгойн хэт их өсөлт болон эрчим хүчний гол эх үүсвэр нь нүүрс байдагтай холбоотой байна.

Манай улсын нийт өрхийн 20 орчим хувийг малчин өрх бүрдүүлдэг ба малчин өрхүүдийн 80 гаруй хувь нь 500 хүртэлх тооны мал хөрөнгөтэй. Ган, зуд зэрэг гамшигт үзэгдлийн давтамж нэмэгдэх нь малчин өрхүүдийн орлогын эх үүсвэрийн баталгаатай байдлыг сулруулах, мал аж ахуйн үйлдвэрлэл буурах, түүхий эдийн нөөц тасалдах, улмаар эдийн засгийн үйл ажиллагаа саарах, ядуурал, орлогын тэгш бус байдал нэмэгдэх зэрэг олон талын сөрөг үр дагавартай.


Зураг 1.2 Хүлэмжийн хийн ялгарал

1. Хүлэмжийн хийн ялгарал болон шингээлт (сая тонн, CO₂-той дүйцэхүйц хий)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо
Тэмдэглэл: Хүлэмжийн хийн ялгарал болон шингээлтийн зөрүүгээр цэвэр дүнг тодорхойлов.

2. Хүлэмжийн хийн ялгарлын эх үүсвэр (сая тонн, CO₂-той дүйцэхүйц хий, 2020 он)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Иймд Монгол Улс 2016 оны 9 дүгээр сарын 1-ний өдөр “Уур амьсгалын өөрчлөлтийн тухай Нэгдсэн Үндэстний Байгууллагын суурь конвенцын Парисын хэлэлцээрийг соёрхон батлах тухай” хуулийг баталж, Парисын хэлэлцээрийг хэрэгжүүлэх зорилгоор “Парисын хэлэлцээрийг хэрэгжүүлэх үндэсний хэмжээнд тодорхойлсон хувь нэмрийн зорилт”-ыг Засгийн газрын 2019 оны 407 дугаар тогтоолоор баталсан. Парисын хэлэлцээрийн хүрээнд гишүүн улс орнууд өөрсдийн үндэсний хэмжээний хувь нэмрийн зорилтыг тодорхойлж, таван жил тутам зорилтыг ахиулан, хэрэгжилтийг тайлагнах үүрэгтэй. Үүний хүрээнд Монгол Улс үндэсний хүлэмжийн хийн ялгарлаа² 2010 оны суурь нөхцөлийн төсөөлөлтэй харьцуулахад 2030 он гэхэд 22.7 хувиар буюу 16.89 сая тонн CO₂-той дүйцэхүйц хийг бууруулахаар зорилт тавьсан.

Нүүрстөрөгчийн үнийг нэвтрүүлсэн олон улс дахь туршлага

Нүүрстөрөгчийн үнэ тогтоох механизм нь уур амьсгалын өөрчлөлтийг нөлөөллийг бууруулах, Парисын хэлэлцээрийн зорилт буюу дэлхийн дундаж температурын өсөлтийг 2 хэмээс хэтрүүлэхгүй байж, 1.5 хэмд хязгаарлах, хүлэмжийн хийн ялгарлыг багасгахад үр дүнтэй бодлогын арга хэрэгсэл юм. Дэлхий даяар нүүрстөрөгчийн үнэ тогтоож байгаа улс орны тоо нэмэгдэж, 2024 оны байдлаар нийт 75 төрлийн нүүрстөрөгчийн татвар, арилжааны систем³ бий болсон байгаа хэдий ч энэ нь дэлхийн нийт хүлэмжийн хийн ялгарлын 24 орчим хувийг л хамарч байна (Дэлхийн банк, 2024). Нүүрстөрөгчийн үнэ нь нүүрстөрөгчийн татвар, арилжааны систем, нүүрстөрөгчийн кредитийн механизм зэрэг олон хэлбэртэй байдаг бөгөөд уян хатан дизайн, шинэ хандлагууд бий болсоор байна. Дэлхийн нийт ялгарлын 60 хувийг, зорилтоос илүү ялгаруулж буй хүлэмжийн хийн 80 хувийг бага болон дунд орлоготой улсууд ялгаруулж байгаа бөгөөд нүүрстөрөгчийн үнэ нь өндөр орлоготой улсуудын ялгарлын 31 хувь, дунд орлоготой улсуудын ялгарлын

² Хүлэмжийн хий гэдэг нь хэт улаан туяаг шингээн авч буцаан туяаруулах шинж чанартай байгалийн буюу хүний үйл ажиллагааны гаралтай хийн мандлын бүрэлдэхүүн хэсэг юм. Үүнд нүүрсхүчлийн хий (CO₂), метан хий (CH₄), азотлог исэл (N₂O), гидрофторт нүүрстөрөгчийн нэгдлүүд (HFCs), перфторт нүүрстөрөгчийн нэгдлүүд (PFCs), гексафторт хүхэр (SF₆) зэрэг орно (Үндэсний статистикийн хороо, 2023).

³ 39 татварын арга хэрэгсэл, 36 арилжааны систем

22 хувийг хамарч байгаа нь бага, дунд орлоготой улсууд нүүрстөрөгчийн үнэ тогтоох механизмыг нэвтрүүлэх шаардлага, хэрэгцээг улам нэмэгдүүлж байна.

Нүүрстөрөгчийн татвар нь хүлэмжийн хийн ялгаруулалтад үндэслэн тодорхой салбар болон үйл ажиллагаанд ногдуулах татвар бөгөөд татварын суурийг нэмэгдүүлэх, төсвийн орлогын нэмэлт эх үүсвэр бий болох, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах ач холбогдолтой. Уг татвараас олсон орлогыг нийгмийн эмзэг өрх, бүлгүүдэд дэмжлэг үзүүлэх, төрийн үйлчилгээг санхүүжүүлэх, гадаадын зээл, тусламжаас хараат байдлыг бууруулах, тогтвортой хөгжлийн зорилтод нийцсэн хөрөнгө оруулалтыг дэмжихэд зарцуулах боломжтой бөгөөд оновчтой боловсруулсан, өсөн нэмэгдэх тогтолцоотой нүүрстөрөгчийн татварын бодлого хэрэгжүүлснээр эдийн засаг, нийгмийн үр өгөөжийг нэмэгдүүлэх боломжтой. Нүүрстөрөгчийн үнээс олсон орлого дэлхийн хэмжээнд 2023 онд анх удаа 104 тэрбум ам.долларт хүрсэн бөгөөд үүний талаас илүү хувийг уур амьсгалын өөрчлөлт, байгаль орчин, ногоон хөгжлийн төслүүдийг санхүүжүүлэхэд зарцуулжээ.


Нүүрстөрөгчийн татварын өрхийн зардалд үзүүлэх нөлөө

Монгол Улсын хувьд нэг тонн нүүрстөрөгчийн ялгарал тутамд нүүрстөрөгчийн татварыг эдийн засгийн үйл ажиллагааны бүх салбарт тогтоох, зөвхөн эрчим хүчний салбарт тогтоох, зөвхөн автомашинд тогтоох байдлаар нүүрстөрөгчийн татварын орлогыг бүрдүүлж, орлогыг тэтгэмж хэлбэрээр буцаан олгоход орлогын түвшнээр ялгаатай өрхүүдэд хэрхэн нөлөөлөх талаар талаар “Mercator Research Institute on Global Commons and Climate Change” судалгааны байгууллагаас⁴ тооцон гаргасан.


Уг тооцоолол нь бодлогын олон хувилбаруудыг харьцуулах боломжийг агуулсан бөгөөд эдгээр хувилбарууд дундаас эрчим хүчний салбараас ялгарч буй 1 тонн нүүрсхүчлийн хий тутамд 1 ам.долларын татвар ногдуулах хувилбарыг сонгон, хот, хөдөөгийн орлогоор ялгаатай өрхүүдэд үзүүлэх тооцооллыг хийж, үр дүнг Зураг 1.3-т харууллаа. Үүнд, хотод амьдардаг, хамгийн өндөр орлоготой (орлогын 10 дах бүлэг) өрхүүд бусад бүлэгтэй харьцуулахад хамгийн бага нүүрсхүчлийн хийн татварын дарамтыг хүлээж байгаа бол орлого буурах тусам өрхийн зардалд үзүүлэх дарамт нэмэгдэх хандлагатай байна. Нүүрсхүчлийн хийн татвараас төвлөрүүлсэн бүх орлогыг тэтгэмж хэлбэрээр өрх бүрд эсвэл хүн бүрд жигд хуваарилан олгох үеийн өрхийн зардалд үзүүлэх нөлөөг Зураг 1.4-т харьцуулан харууллаа.

Зураг 1.3 Нүүрсхүчлийн хийн татварын өрхийн зардалд үзүүлэх нөлөө

1. Нэмэгдэл харьцангуй зардлын тархалт, өрхийн орлогын бүлгээр



2. Нэмэгдэл харьцангуй дундаж зардлын хувь, өрхийн орлогын бүлгээр



Босоо тэнхлэг: Орлогын бүлгүүд. Энд 1 гэсэн утга нь өрхүүдийг орлогын эрэмбэлэн 10 тэнцүү хэсэгт хуваасны хамгийн бага орлоготой хэсгийг, 10 гэсэн утга нь хамгийн өндөр орлоготой өрхүүдийг илэрхийлнэ.

Хэвтээ тэнхлэг: Нэмэгдэл харьцангуй зардал, хувь.

Эх сурвалж: <https://www.cpic-global.net/country/MNG>

Тэмдэглэл: Нэмэгдэл харьцангуй зардал гэж татварын нэмэгдэлтэй холбогдон гарах нэмэлт зардлыг өрхийн дундаж зардалд харьцуулсан хувь

⁴ Германы Олон Улсын Хамтын Ажиллагааны нийгэмлэгийн санхүүжилтээр “Mercator Research Institute on Global Commons and Climate Change судалгаа хүрээлэн” нь нүүрсхүчлийн хийн татварын нөлөөг тооцох аргачлалыг боловсруулан, өгөгдлийн санг үүсгэж, татварын нөлөөллийн үр дүнг харуулах Carbon Pricing Incidence Calculator (CPIIC) тооцоолуурыг олон нийтэд нээлттэй, цахим хэлбэрээр танилцуулсан. Монгол Улсын хувьд 11 гаруй мянган өрх түүвэр судалгаанд хамрагдсан байна. Цахим хаягийн холбоос <https://www.cpic-global.net/country/MNG>.

А. Татварын буцаан олголтыг өрх бүрд жигд олгох:

Татварын орлогоос ямар нэг хэлбэрээр тэтгэмж олгоогүй үед орлого багатай өрхүүдэд үзүүлэх дарамт харьцангуй өндөр байна. Харин татварын буцаан олголтыг өрх бүрд жигд байдлаар буцаан шилжүүлбэл хотын өрхүүдийн зардлын дарамт орлогын бүх бүлэгт ойролцоо түвшинд хүрч, дунджаар 0.02 хувиар харьцангуй зардлыг нэмэгдүүлж байна. Харин хөдөө амьдардаг өрхүүдийн хувьд нүүрсхүчлийн хийн ялгаруулалтад төлсөн татвараас буцаан олголтоор хүлээн авсан мөнгөн дүн нь өндөр байгаа тул өрхийн зардлын дарамтыг бууруулах нөлөөтэй байна

Б. Татварын буцаан олголтыг хүн бүрд жигд олгох:

Нүүрсхүчлийн хийн татварын орлогыг хүн бүрд жигд хуваарилан олгоход орлого багатай өрхүүдийн зардлын дарамтыг бууруулж, орлого өндөр өрхүүдийн зардлын дарамтад маш бага нөлөө үзүүлж байна. Нүүрсхүчлийн хийн татварын орлогыг хүн бүрд жигд олгох нь орлого бага өрхүүдийн зардлын дарамтыг бууруулж байгаа бол өрх бүрд жигд хуваарилан олгоход өрхийн зардлын дарамт орлогын бүлгээс үл хамааран ойролцоо түвшинд хүрч байна.


Эх сурвалж:

"State and Trends of Carbon Pricing 2024", World bank, 2024.


"Policy Brief: Macroeconomic Effects of Carbon Pricing in Mongolia", GIZ, 2024.

Зураг I.4 Нүүрсхүчлийн хийн татварын орлогын хуваарилалт

1. Нүүрсхүчлийн хийн татварын орлогыг өрх бүрд тэнцүү хуваарилан, буцаан шилжүүлэх үеийн нэмэгдэл харьцангуй зардлын тархалт, өрхийн орлогын бүлгээр



2. Нүүрсхүчлийн хийн татварын орлогыг хүн бүрд тэнцүү хуваарилан, буцаан шилжүүлэх үеийн нэмэгдэл харьцангуй дундаж зардлыг хувь, өрхийн орлогын бүлгээр



Босоо тэнхлэг: Орлогын бүлгүүд. Энд 1 гэсэн утга нь өрхүүдийг орлогын эрэмбэлэн 10 тэнцүү хэсэгт хуваасны хамгийн бага орлоготой хэсгийг, 10 гэсэн утга нь хамгийн өндөр орлоготой өрхүүдийг илэрхийлнэ.

Хэвтээ тэнхлэг: Нэмэгдэл харьцангуй зардал буюу татварын нэмэгдэлтэй холбогдон гарах нэмэлт зардлыг өрхийн дундаж зардалд харьцуулсан хувь.

Эх сурвалж: <https://www.cpici-global.net/country/MNG>

Эх сурвалж: <https://www.cpici-global.net/country/MNG>

9. Эдийн засгийн өсөлтийг дотоод эрэлт голлон дэмжлээ. Өрхийн болон төрийн хэрэглээ өсөж, дотоод эрэлт 2024 оны эхний 3 улиралд 20.9 хувиар өслөө. Харин хэрэглээ, хөрөнгө оруулалтыг дагасан импортын өсөлтийн нөлөөгөөр цэвэр экспорт буурч, эдийн засгийн өсөлтөд сөрөг нөлөө үзүүлээ.

10. Өрхийн бодит орлогын өсөлтийн нөлөөгөөр хэрэглээ тэлж байна. Өрхийн нэрлэсэн орлого 2024 оны 3 дугаар улиралд 2.6 сая төгрөг болж, бодит орлого 10 хувиар өссөнөөр өрхийн хэрэглээ тэллээ. Төрийн албан хаагчдын цалинг нэмэгдүүлснээр төрийн байгууллагын дундаж цалин 2024 оны 2 дугаар улирлын байдлаар өмнөх оны мөн үеэс 57.6 хувиар өсөв. Үүнийг дагаад хувийн хэвшлийн дундаж цалин мөн 21-27 хувиар нэмэгдлээ. Мөн бараа, үйлчилгээний үнэ тогтвортой байж, ажиллах хүчний оролцооны түвшин болон зээл олголт нэмэгдсэн зэрэг эерэг өөрчлөлтүүд нь өрхийн хэрэглээ тэлэхэд нөлөөлж байна. Үндэсний судалгаа зөвлөгөөний төв (Эн-Ар-Си-Си)-өөс улирал тутам гаргадаг хэрэглэгчдийн эдийн засагт итгэх итгэлийн судалгаагаар хэрэглэгчийн итгэл 2024 оны 3 дугаар улиралд өмнөх улирлаас 6.1 нэгжээр өссөн байна.

11. Бага орлоготой өрхүүдийн орлого улсын дунджаас доогуур өсөлттэй байна. Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгааны мэдээллээр улсын

хэмжээнд нийт 983 мянган өрх бүртгэлтэй байгаагаас 351 мянган өрх нь 1.6 сая төгрөгөөс бага орлоготой байна. Эдгээр өрхүүдийн нэрлэсэн дундаж орлого 967 мянган төгрөг байгаа нь улсын дунджаас 2.7 дахин, 1.6 сая төгрөгөөс дээш орлоготой өрхүүдийн дунджаас даруй 3.3 дахин бага байна. Өндөр орлоготой өрхийн орлогын 61 хувийг цалингийн орлого бүрдүүлж байгаа бол бага орлоготой өрхийн орлогын дийлэнх буюу 57 хувийг тэтгэвэр, тэтгэмжийн орлого, харин цалингийн орлого ердөө 22 хувийг бүрдүүлж байна. Өөрөөр хэлбэл бага орлоготой өрхийн хөдөлмөр эрхлэлтийн түвшин доогуур байгаагаас цалингийн өсөлт эдгээр өрхийн орлогод үзүүлэх нөлөө бага байна. Улаанбаатар хотын нийт өрхийн 20.9 хувь нь 1.6 сая төгрөгөөс бага орлоготой өрхүүд байгаа бол харин хөдөөгийн өрхийн 60.2 хувь нь бага орлоготой байна.

12. Хөрөнгийн хуримтлалын өсөлтөд уул уурхайн машин механизмын импорт болон барилга угсралтын ажил эрчимжсэн нь голлон нөлөөллөө. Тухайн хугацаанд эдийн засгийн салбаруудын үндсэн болон эргэлтийн хөрөнгийн нөөцөд гарсан өсөлт, бууралт, шинэ хөрөнгө оруулалтыг бүртгэдэг хөрөнгийн хуримтлал 2024 оны эхний 3 улиралд өмнөх оны мөн үеэс 25.2 хувиар нэмэгдлээ. Энэ оны эхний хагас жилд хөрөнгийн нийт хуримтлалд материаллаг эргэлтийн хөрөнгийн

Зураг 1.5. Өсөлтийн бүтэц (эрэлт талаас)



өсөлт давамгайлж байсан бол 3 дугаар улиралд үндсэн хөрөнгө 17.7 хувиар өсөж, хөрөнгийн нийт хуримтлалын өсөлтөд эерэг нөлөө үзүүллээ. Үндсэн хөрөнгийн өсөлтөд машин тоног төхөөрөмжийн нөөц өмнөх оны мөн үеэс 42.2 хувиар, орон сууцны бус барилга угсралтын ажил 15.2 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлж, малын тооны хорогдлоос үүдэлтэй үндсэн хөрөнгийн бууралтыг сааруулсан байна.

13. Төсвийн хөрөнгө оруулалт нэмэгдсэн бол хувийн секторын хөрөнгө оруулалт удаашралтай байна. Улаанбаатар хотын авто зам, гүүрний засвар болон Өмнөговь, Дорноговь аймгуудад хэрэгжиж буй авто болон төмөр замын бүтээн байгуулалтын ажлууд төсвийн хөрөнгө оруулалтад голлож, 2024 оны эхний 3 улирлын байдлаар төсвийн хөрөнгө оруулалт бодит дүнгээр

өмнөх оны мөн үеэс 50 хувиар өссөн байна. Хэдийгээр аж ахуйн нэгжүүдэд олгосон зээлийн хэмжээ өсөлттэй байгаа ч хувийн секторын хөрөнгө оруулалт 3.8 хувиар буурсан байна.

14. Импорт эрчимжсэнээр цэвэр экспорт буурч, эдийн засгийн өсөлтөд сөргөөр нөлөөллөө.

Цэвэр экспорт нь бараа, үйлчилгээний экспортын орлого болон импортын зардлын зөрүүг илэрхийлдэг. Гадаад зах зээл дээр бараа бүтээгдэхүүний үнэ тогтворжиж, импортын үнэ буурсан. Эдийн засгийн идэвхжилийг дагаад хэрэглээ болон хөрөнгө оруулалтын импорт эрчимжиж, оны эхний 3 улирлын байдлаар бараа, үйлчилгээний импорт өмнөх оны мөн үетэй харьцуулахад 19.3 хувиар нэмэгдсэнээр цэвэр экспорт 89.9 хувиар буурав.


ХӨДӨЛМӨР БА АЖ АХУЙН НЭГЖ

15. Эдийн засгийн өсөлтийн нөлөөгөөр хөдөлмөрийн зах зээл тэлж, ажил эрхлэлт нэмэгдсээр байна. 2024 оны 3 дугаар улиралд ажилчдын тоо өмнөх оны мөн үеэс 34 мянгаар, цар тахлын өмнөх үеэс 121 мянгаар нэмэгдэж 1 сая 360 мянгад хүрлээ. Ажилчдын тоог улирлын нөлөө⁵ арилган тооцвол өмнөх оны мөн үеэс 51 мянгаар нэмэгдсэн байна. Энэхүү өсөлтөд үйлчилгээний салбарт 46 мянга, худалдааны салбарт 26 мянга, тээврийн салбарт 11 мянган ажилчид нэмэгдсэн нь голчлон нөлөөлсөн байна. Харин хөдөө аж ахуйн салбарын уналтын нөлөөгөөр салбарын ажилчдын тоо өмнөх оны мөн үеэс 50 мянгаар, боловсруулах салбарын ажилчид 3 мянгаар, цахилгаан, усан хангамжийн салбарын ажилчид 1 мянгаар буурсан нь өсөлтийн хурдыг сааруулаа. Байршлаар авч үзвэл, ажилчдын тоо Улаанбаатар хотод өмнөх оны мөн үеэс 62 мянгаар өсөж 624 мянгад хүрсэн бол

хөдөөд 28 мянгаар буурч 736 мянга болсон байна. Тодруулбал, ажилчдын тоо Хангайн бүсэд 18 мянга, Төвийн бүсэд 7 мянга, Баруун бүсэд 3 мянгаар тус тус буурсан байна.

16. Иргэд ажиллах хүчнээс гадуурх хүн амаас ажиллах хүчний эгнээнд шилжсэнээр хөдөлмөр эрхлэлтийн үзүүлэлт сайжирлаа. Ажиллах хүч өмнөх оны мөн үеэс 48 мянгаар нэмэгдэж 1 сая 448 мянгад хүрлээ. Ажиллах хүч ийнхүү өссөнөөр ажиллах хүчний оролцооны түвшин өмнөх оны мөн үеэс 1.0 нэгж хувиар нэмэгдэж 63 хувьд хүрсэн нь сүүлийн 10 жилийн хамгийн өндөр үзүүлэлт боллоо. Харин улирлын нөлөөг арилган тооцвол ажиллах хүчний оролцооны түвшин 60.9 хувь буюу өмнөх оны мөн үеэс 0.9 нэгж хувиар өссөн үзүүлэлттэй байна. Ажиллах хүчний өсөлтөд ажилчдын тооны өсөлтөөс гадна ажиллах хүчнээс гадуурх хүн ам өмнөх оны мөн

Зураг 1.6. Хөдөлмөрийн зах зээл



⁵ Улирлын нөлөөг арилгах гэдэг нь хугацаан цувааны өгөгдөл дэх улирлын тогтмол хэв шинжүүдийг арилгах статистикийн арга юм. Эдгээр хэв шинжүүд нь цаг агаарын өөрчлөлт, баяр ёслол, сургууль, цэцэрлэгийн хуваарь, хөдөө аж ахуйн цикл гэх мэт янз бүрийн хүчин зүйлсээс шалтгаалж бий болдог. Энэхүү тогтмол хэлбэлзлийг арилгаснаар өгөгдөл дэх бодит чиг хандлага, мөчлөгийн хөдөлгөөнүүдийг ажиглахад хялбар болгодог бөгөөд өөр өөр хугацааны мэдээллийг хооронд нь харьцуулах боломжийг олгодог.

үеэс 23 мянгаар буурсан нь чухал нөлөө үзүүлээ. Үүнийг боломжит ажиллах хүч буюу хөдөлмөр эрхлэх сонирхолтой ч ажиллах боломжгүй байсан иргэдийн тооны бууралт тайлбарлаж байна. Энэ нь хөдөлмөрийн зах зээлийн идэвхжил болон ажиллах хүчний өсөлтийг дэмжсэн эерэг үзүүлэлт боллоо.


17. Мэргэжил, дадлага туршлагагүй шалтгаантай ажилгүй иргэд нэмэгдэв. Ажилгүй иргэдийн тоо өмнөх оны мөн үеэс 14 мянгаар буюу 19 хувиар өсөж 88.1 мянгад хүрэв. Ингэснээр ажилгүйдлийн түвшин өмнөх оны мөн үеэс 1 нэгж хувиар өсөж 6.1 хувьд хүрлээ. Ажилгүй иргэдийн тооны өсөлтийг шалтгаанаар салган харвал, мэргэжил, дадлага туршлага байхгүй иргэд 4.6 мянгаар, гадаадад амьдарч байгаад ирсэн иргэд 2.7 мянгаар, улирлын чанартай ажил хийдэг иргэд 1.2 мянгаар тус тус нэмэгдсэн нь голчлон нөлөөлсөн байна. Харин ажиллах сонирхолгүй иргэд 1.5 мянгаар, жирэмсэн, хүүхэд асарсан иргэд 1 мянгаар, байгууллага татан буугдсан шалтгаантай ажилгүй иргэдийн тоо 0.7 мянгаар буурсан байна.

18. Улсын дундаж цалин нэмэгдэж байна. Үндэсний статистикийн хорооноос зарласнаар 2024 оны 3 дугаар улиралд нэрлэсэн дундаж цалин өмнөх оны мөн үеэс 470 мянгаар өсөж 2 сая 450 мянган төгрөг, голч цалин өмнөх оны мөн үеэс 468 мянгаар өсөж 2 сая 24 мянган төгрөг болсон байна. Хэдийгээр дундаж цалин 2.5 сая төгрөгт хүрсэн хэдий ч ажилчдын талаас илүү хувь нь 2 сая төгрөгөөс доош цалин авч байгааг голч цалингийн хэмжээ илтгэж байна.

Дундаж цалинг салбараар авч үзвэл уул уурхайн салбарын цалин хамгийн өндөр буюу 5 сая 196 мянган төгрөг хүрсэн нь улсын дунджаас 2.1 дахин их байна. Түүнчлэн цахилгаан, усны салбарын ажилчдын дундаж цалин өмнөх оны мөн үеэс 1 сая 68 мянган төгрөгөөр өсөж 3 саяд хүрсэн нь улсын дундаж цалингийн өсөлтөд эергээр нөлөөллөө. Харин байр, сууц, хүнсний үйлчилгээний салбарын цалин 1 сая 611 мянган төгрөг байгаа нь улсын дунджаас 1.6 дахин бага байна.

Хөдөлмөрийн зах зээлийн www.zangia.mn цахим хуудаст 2024 оны 3 дугаар улиралд зарлагдсан 32 мянган⁵ ажлын байрны цалинг авч үзвэл дунджаар 2 сая 554 мянган төгрөг байгаа нь улсын дунджаас 104 мянган төгрөгөөр өндөр, голч цалинг тооцож үзвэл 2 сая 300 мянган төгрөг байсан нь улсын дунджаас 276 мянган төгрөгөөр өндөр байна. Салбараар харвал хамгийн өндөр дундаж цалинтай салбарт барилга 3 сая 100 мянга, уул уурхай 3 сая, маркетинг, борлуулалт 2 сая 800 мянган төгрөг байх бол хамгийн бага буюу 2.0-2.1 сая төгрөгийн дундаж цалинтай салбаруудад хэвлэл мэдээлэл, үйлчилгээ, аялал жуулчлалын салбар хамрагдаж байна.

Зураг 1.7. Улсын дундаж болон голч цалин, хөдөлмөрийн зах зээлд зарлагдсан ажлын байрны цалин



Зураг 1.7-оос харвал www.zangia.mn цахим хуудаст зарлагдсан ажлын байрны дундаж цалин болон голч цалин нь улсын дундаж цалин болон голч цалингаас 4 хувь, 14 хувиар тус тус өндөр байгаа нь харагдаж байна. Энэ нь тус цахим хуудаст ажлын байрны зар байршуулж байгаа аж ахуйн нэгжийн хэмжээ, зарлагдаж буй ажлын байрны онцлогоос гадна тухайн ажлын байранд ажиллах хүч хязгаарлагдмал байх зэрэг шалтгаанаас үүдэн зарлагдаж буй ажлын байрны цалин улсын дунджаас өндөр байх магадлалтай.

19. Уул уурхайгаас бусад салбарын бүтээмжийн түвшин буурсан нь хөдөлмөрийн бүтээмжийн түвшний өсөлтийг удаашрууллаа. Хөдөлмөрийн бүтээмжийн түвшин өмнөх оны мөн үеэс 76.5 мянган төгрөгөөр буюу 1 хувиар өсөж 5 сая 908 мянган төгрөгт хүрлээ. Салбараар авч үзвэл уул уурхайн салбарын бүтээмж өмнөх оны мөн үеэс 85.8 мянган төгрөгөөр өсөж 15 сая 567 мянган төгрөгт хүрсэн нь хөдөлмөрийн бүтээмжийн улсын дундаж түвшнээс ойролцоогоор 3 дахин өндөр байна. Харин хөдөө аж ахуйн салбарын бүтээмжийн түвшин салбарын бууралтын нөлөөгөөр 288.9 мянган төгрөгөөр буюу 10.2 хувиар буурч 2 сая 546 мянга төгрөг болсон байна. Түүнчлэн салбарын ажилчдын өсөлтийн нөлөөгөөр аж үйлдвэр, барилга, үйлчилгээний салбарын бүтээмжийн түвшин өмнөх оны мөн үеэс харгалзан 199.4 мянган төгрөг, 102.2 мянган төгрөгөөр буурч 3 сая 758 мянга, 5 сая 434 мянган төгрөгт хүрлээ.

20. Дотоод эдийн засгийн идэвхжил ААН-ийн үйл ажиллагааг идэвхжүүллээ. 2024 оны 3 дугаар улирлын байдлаар Бизнес регистрийн санд бүртгэлтэй нийт ААН-үүд 250.8 мянгад хүрч өмнөх оны мөн үеэс 20.2 мянгаар нэмэгдлээ. Уг өсөлтийн

⁵ Эдгээр ажлын байрны 4.6 мянга нь санхүү, даатгалын салбарт, 4.2 мянга нь уул уурхайн салбарт, 4.1 мянга нь худалдааны салбарт, 2.8 мянга нь үйлдвэрлэл, барилгын салбарт, 2.6 мянга нь үйлчилгээний салбарт, 11 мянга нь бусад салбарт зарлагдсан байна.

12.7 мянгыг үйл ажиллагаа эхлээгүй буюу шинээр байгуулагдсан ААН-үүд бүрдүүлсэн бол 6.8 мянгыг үйл ажиллагаа явуулж буй ААН-үүд бүрдүүллээ. Үйл ажиллагаа явуулж буй болон шинээр байгуулагдсан ААН-ийн тоо нэмэгдэж байгаа нь бизнесийн үйл ажиллагаа идэвхжиж байгааг илтгэж байна.

Салбараар харвал, худалдаа, үйлчилгээний салбарт шинээр байгуулагдсан ААН 8.3 мянгаар, үйл ажиллагаа явуулж буй ААН 4.6 мянгаар нэмэгдсэн нь ААН-ийн өсөлтийн гол хэсгийг бүрдүүлж байна. Тэр дундаа тус салбарт шинээр байгуулагдсан ААН-ийн тоо тухайн улирлын сүүлийн 10 жилийн дундаж 9.4 хувийн өсөлтөөс 33.4 хувиар давж өсжээ. Худалдаа, үйлчилгээний салбарын ААН-үүд нэмэгдэхэд эдийн засаг идэвхжиж, өрхийн орлого нэмэгдсэн нь эергээр нөлөөллөө. Тодруулбал, бүх төрлийн барааны бөөний болон жижиглэнгийн худалдааны ААН-үүд, тэр дундаа хүнс, ундаа, тамхи болон хөдөө аж ахуйн түүхий эд, мал, амьтдын бөөний болон жижиглэн худалдаа эрхэлдэг ААН-үүд ихээхэн нэмэгджээ.

Мөн тээврийн салбарын өсөлттэй холбоотойгоор тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн худалдаа эрхэлдэг ААН-үүд нэмэгдсэн байна. Аялал жуулчлалын салбарын хувьд 2023-2025 оныг Монголд зочлох жил болгон зарласан бөгөөд аялал жуулчлалыг дэмжих бодлого, арга хэмжээний үр дүнд аялал жуулчлал, ресторан, байр сууцаар хангах үйлчилгээний ААН-үүд нэмэгджээ. Түүнчлэн төрийн бус байгууллага, үйлдвэрчний эвлэл, эмнэлэг, сургалтын төв, бизнесийн зөвлөх үйлчилгээ, компьютер програмчлал, архитектур болон инженерийн үйл ажиллагаа эрхэлдэг ААН-үүд нэмэгджээ.

Мөн хөдөө аж ахуйг дэмжих бодлого хэрэгжүүлсэнтэй холбоотойгоор тус салбарын ААН-ийн тоо сүүлийн 10 жилийн дунджаас үйл ажиллагаа явуулж буй ААН-ийн хувьд 19.1 хувиар, шинээр байгуулагдсан ААН-ийн хувьд 144.9 хувиар илүү өсөлттэй байна. Задалж харвал мал, амьтан өсгөх, үржүүлэх аж ахуйн үйл ажиллагаа, холимог фермерийн аж ахуй, хөдөө аж ахуй болон ургац хураалтын дараах шатны үйл ажиллагааг дэмжсэн туслах үйл ажиллагаа эрхэлдэг ААН-үүд нэмэгджээ (Зураг 1.8).

Уул уурхайн салбарын хувьд экспортын өсөлтийн нөлөөгөөр идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа ААН-ийн тоо уул уурхайн салбарт 79, тээврийн салбарт 397 ААН-ээр нэмэгдсэн бол шинээр байгуулагдсан ААН-ийн тоо уул уурхайн салбарт 67, тээврийн салбарт 721 ААН-ээр нэмэгджээ. Тээврийн салбарт шинээр байгуулагдсан ААН-ийн өсөлт нь сүүлийн 10 жилийн дунджаас 48.2 хувиар өндөр байна.

21. Худалдаа, үйлчилгээ эрхлэгч жижиг ААН-үүд нэмэгдлээ. Бизнес регистрийн санд бүртгэлтэй үйл ажиллагаа явуулж буй 104.6 мянган ААН-ийн 86.2

хувь буюу 90.1 мянган ААН нь 1-9 ажилтантай байна (Хүснэгт 1). 1-9 ажилтантай жижиг ААН өмнөх оны мөн үеэс 6.3 мянгаар нэмэгдсэнээс 4.4 мянган ААН нь худалдаа, үйлчилгээний салбарт үйл ажиллагаа явуулж байна (1-9 ажилтантай ААН-ийн 76 хувь буюу 68.9 мянган ААН худалдаа, үйлчилгээ эрхэлж байна). Харин 10-19 ажилтантай ААН 6.4 мянгад хүрч өмнөх оны мөн үеэс 319 ААН-ээр нэмэгдэхэд хөдөө аж ахуй, үйлчилгээ, барилгын салбарт үйл ажиллагаа эрхэлдэг ААН-үүд нэмэгдсэн нь нөлөөллөө. Мөн 20-49 ажилтантай 87 ААН, 50-иас дээш ажилтантай 65 ААН шинээр үйл ажиллагаа явуулж эхэлсний 80-90 хувийг үйлчилгээний салбар бүрдүүллээ.

22. ААН-ийн борлуулалтын орлогын өсөлтийн дийлэнхийг үйлчилгээний салбар бүрдүүллээ.

2024 оны 3 дугаар улирлын байдлаар ААН-ийн бодит борлуулалтын орлого өмнөх оны мөн үеэс 17.0 хувиар өсөж 22.7 их наяд төгрөгт хүрлээ. Уг өсөлтийн 6.0 нэгж хувийг үйлчилгээний салбар бүрдүүлсэн бөгөөд тэр дундаа тус салбарын гол хэсгийг бүрдүүлдэг бөөний болон жижиглэн худалдааны салбар өсөлттэй байсан нь нөлөөллөө. Түүнчлэн уул уурхайн салбар борлуулалтын орлогын өсөлтийн 5.2 нэгж хувийг, хөдөө аж ахуй 3.4 нэгж хувийг, тээвэр 1.7 нэгж хувь, ус, цахилгаан 0.9 нэгж хувийг тус тус бүрдүүлсэн байна. Харин барилга болон боловсруулах салбарын ААН-ийн орлого өмнөх оны мөн үеэс буурсан үзүүлэлттэй байна.

Хүснэгт 1. Үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжийн тооны өөрчлөлт, ажиллагчдын тоогоор

Ажилчдын тооны бүлэг	ААН тоо, мянга	Өөрчлөлт, хувь	Тайлбар
1-9	90.1	7.5%	Өсөлтийн 2/3-ыг худалдаа, үйлчилгээний салбар бүрдүүлсэн.
10-19	6.4	5.3%	Өсөлтийн 1/3-ийг хөдөө аж ахуй, 1/3-ийг худалдаа, үйлчилгээ, 13 хувийг барилгын салбар бүрдүүлсэн.
20-49	5.2	1.7%	Шинээр 87 ААН үйл ажиллагаа явуулж эхэлснээс 72 ААН үйлчилгээ, 15 ААН барилга, 11 ААН боловсруулах салбарт байна. Харин худалдааны салбарт 32 ААН буурсан байна.
50-иас дээш	2.9	2.3%	Шинээр 65 ААН үйл ажиллагаа явуулж эхэлснээс 61 ААН үйлчилгээ, 12 ААН тээвэр, 7 ААН уул уурхай, 6 ААН барилгын салбарт байна. Харин худалдааны салбарт 19 ААН буурсан байна.
Нийт	104.6	6.9%	


Зураг 1.8. Аж ахуйн нэгж

1. Үйл ажиллагаа явуулж буй болон үйл ажиллагаа эхлээгүй ААН-ийн тооны өөрчлөлт, салбараар (ААН-ийн тоо)




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

2. Нийт бүртгэлтэй ААН-ийн тоо (мянга)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

3. ААН-ийн бодит борлуулалт (их наяд төгрөг, 2015=100)



Эх сурвалж: Татварын ерөнхий газар

ШИГТГЭЭ 2. ХЭРЭГЛЭГЧИЙН ИТГЭЛИЙН ИНДЕКС

2024 ОНЫ 3 ДУГААР УЛИРАЛД ХЭРЭГЛЭГЧДИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ХҮЛЭЭЛТ САЙЖИРЧ ХЭРЭГЛЭГЧИЙН ИТГЭЛИЙН ИНДЕКС ӨМНӨХ ОНЫ МӨН ҮЕЭС 9.9 НЭГЖЭЭР, ӨМНӨХ УЛИРЛААС 6.1 НЭГЖЭЭР НЭМЭГДЛЭЭ.


Үндэсний судалгаа зөвлөгөөний төв (Эн-Ар-Си-Си ХХК) болон Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төвөөс тооцон гаргадаг Хэрэглэгчийн итгэлийн индекс (ХИИ)-ээр эдийн засгийн ерөнхий байдал болон өрхийн санхүүгийн байдлын талаар хэрэглэгчид хэр зэрэг өөдрөг бодолтой байгааг хэмждэг. Хэрэглэгчийн итгэлийн индексийг Өнөөгийн байдлын индекс /бизнесийн нөхцөл, ажлын олдоц/, Ирээдүйн хүлээлтийн индекс /бизнесийн нөхцөл, ажлын олдоц, орлого/ гэсэн 5 үзүүлэлтээс бүрдэх 2 дэд индексээр тооцож байна. Ингэхдээ улс даяар санамсаргүй түүврийн аргаар хэрэглэгчдээс санал асуулга авч 0-200-ийн хооронд үнэлдэг бөгөөд индекс 200-д дөхөх тусам хэрэглэгчийн итгэл өндөр, 0-д дөхөх дусам хэрэглэгчийн итгэл сул, харин индекс 100-тай тэнцүү үед эдийн засаг хэвийн байна гэж үздэг.

ХИИ 2024 оны 3 дугаар улиралд 114.8-д хүрсэн нь 2015 оноос хойших хамгийн өндөр үзүүлэлт болсон бөгөөд үүнд хэрэглэгчдийн ирэх 6 сарын эдийн засгийн хүлээлт сайжирсан нь нөлөөллөө. Индексийн үнэлгээг бүрэлдэхүүн хэсгээр задалж Хүснэгт 2-т үзүүлэв.

1. Өнөөгийн байдлын индекс: Бизнесийн нөхцөлийн үнэлэмж муудаж Өнөөгийн байдлын индекс өмнөх оны мөн үеэс 3.4 нэгжээр буурлаа. Өнөөгийн байдлын индекс нь иргэд эдийн засгийн одоогийн нөхцөл, байдлыг бизнесийн нөхцөл болон ажлын олдоц хэр байгаагаар үнэлснээр хэмжигддэг. 2024 оны 3 дугаар улиралд Өнөөгийн байдлын индекс 129.7-д хүрч буурахад бизнесийн нөхцөл "муу" гэж үнэлсэн иргэд өмнөх оны мөн үеэс 9.7 нэгжээр нэмэгдэж 49.0 хувьд хүрсэн нь голчлон нөлөөллөө. Харин судалгаанд оролцогчдын 3 хүн тутмын 2 нь ажлын олдоцыг сайн эсвэл хэвийн гэж үнэлсэн хэвээр байна.

2. Ирээдүйн хүлээлтийн индекс: Хэрэглэгчдийн эдийн засгийн ирэх 6 сарын хүлээлт сайжирч Ирээдүйн хүлээлтийн индекс өмнөх оны мөн үеэс 14.2 нэгжээр нэмэгдлээ. Ирээдүйн хүлээлтийн индекс нь эдийн засгийн ойрын ирээдүйн нөхцөлийг иргэд хэрхэн харж буйг бизнесийн нөхцөл, ажлын олдоц, орлогын хүлээлтийн үнэлгээгээр хэмждэг. 2024 оны 3 дугаар улиралд Ирээдүйн хүлээлтийн индекс 109.9-д хүрч нэмэгдэхэд хэрэглэгчдийн ирэх 6 сарын бизнесийн нөхцөл, ажлын олдоцыг өөдрөгөөр харах хандлага нэмэгдсэн нь голчлон нөлөөллөө. Харин орлого сайжирна гэсэн иргэд 1.4 нэгжээр буурч, хэвийн байна гэсэн иргэд 4 нэгжээр нэмэгджээ.

Зураг 1.9. Хэрэглэгчийн итгэлийн индекс, улирлаар (2018=100)



Эх сурвалж: Үндэсний судалгаа зөвлөгөөний төв (Эн-Ар-Си-Си ХХК)
Тайлбар: ХИИ болон түүний бүрэлдэхүүн индексүүдийг улирлын нөлөөгөөр засварлаж 2018 оны 4 дүгээр улирлын индексэй харьцуулж тооцсон байна.

Хүснэгт 2. Хэрэглэгчийн итгэлийн индексийн бүрэлдэхүүн

	2023.III	2024.III	Өөрчлөлт
ӨНӨӨГИЙН БАЙДАЛ ▼			
Бизнесийн нөхцөл ▼			
Сайн	11.1	11.9	0.80▲
Хэвийн	45.3	38.2	-7.10▼
Муу	39.3	49.0	9.70▲
Ажлын олдоц ▲			
Сайн	33.5	34.0	0.50▲
Хэвийн	31.6	33.3	1.70▲
Муу	31.4	31.1	-0.30▼
ОЙРЫН ИРЭЭДҮЙ ▲			
Бизнесийн нөхцөл ▲			
Сайн	14.7	17.7	3.00▲
Хэвийн	61.0	64.2	3.20▲
Муу	18.7	15.6	-3.10▼
Ажлын олдоц ▲			
Сайн	22.6	31.8	9.20▲
Хэвийн	55.8	51.7	-4.10▼
Муу	17.2	13.4	-3.80▼
Орлого ▲			
Сайн	27.1	25.7	-1.40▼
Хэвийн	53.5	57.5	4.00▲
Муу	17.0	15.3	-1.70▼

Эх сурвалж: Үндэсний судалгаа зөвлөгөөний төв (Эн-Ар-Си-Си ХХК)

ЭДИЙН ЗАСГИЙН МӨЧЛӨГ

23. Үйлдвэрлэлийн машин, тоног төхөөрөмжийн өсөлт, хөдөлмөрийн зах зээлийн сэргэлтийн нөлөөгөөр потенциал үйлдвэрлэлийн өсөлт хадгалагдлаа. Уул уурхайн салбарын үйл ажиллагааны эрчимжилтийг дагасан машин тоног төхөөрөмжийн өсөлтийн голлох нөлөөгөөр үндсэн хөрөнгийн хуримтлал 2024 оны эхний 3 улиралд өмнөх оны мөн үеэс бодит дүнгээр 7.2 хувиар өсөж, нийт эдийн засгийн потенциал үйлдвэрлэлийн өсөлт 4 орчим хувьд хадгалагдлаа. Мөн хөдөлмөрийн зах зээлийн идэвх өндөр байгаа нь потенциал үйлдвэрлэлийн өсөлтийг дэмжлээ.

24. Уул уурхайн салбарын өсөлт, дотоод эдийн засгийн идэвхжилийн нөлөөгөөр үйлдвэрлэлийн сөрөг зөрүү хаагдлаа. Уул уурхайн олборлолт, түүнийг дагасан тээврийн салбарын эрчимжилт болон дотоод эрэлтийн идэвхжил хадгалагдаж үйлчилгээний салбаруудын өсөлтийг тэтгэснээр уул уурхайн болон уул уурхайн бус салбаруудын үйлдвэрлэлийн сөрөг зөрүү хаагдаж, нийт үйлдвэрлэл потенциал түвшнээсээ 0.5 нэгж хувиар өндөр гарлаа.

Зураг 1.10. Үйлдвэрлэлийн зөрүү

1. Потенциал ДНБ-ий өсөлт
(хувь)



Эх сурвалж: ЭЗХЯ-ны тооцоолол
Тэмдэглэл: Потенциал үйлдвэрлэлийг нэг хувьсагчтай шүүлтүүр буюу Ходрик-Прескотт, олон хувьсагчтай шүүлтүүр буюу Калман шүүлтүүр болон үйлдвэрлэлийн функцийн аргачлалаар тус тус тооцов.

2. Үйлдвэрлэлийн зөрүү
(потенциал ДНБ-д эзлэх хувь)



Эх сурвалж: ЭЗХЯ-ны тооцоолол
Тэмдэглэл: Үйлдвэрлэлийн зөрүүг бодит болон потенциал ДНБ-ий зөрүүгээр тооцно. Үйлдвэрлэлийн зөрүүг үйлдвэрлэлийн функцийн аргачлалд тулгуурлан тооцдог байсныг Мөнгөний бодлогын шинжилгээний GAP загварт тулгуурлан олон хувьсагчийн Калманы шүүлтүүрийн аргаар тооцох аргачлалд шилжүүлэн тооцов.

БҮЛЭГ 2

ТӨСВИЙН СЕКТОР

- 2.1 Төсвийн гүйцэтгэл
- 2.2 Төсвийн бодлогын төлөв
- 2.3 Засгийн газрын өрийн тогтвортой байдал

2. ТӨСВИЙН СЕКТОР

ТОЙМ

Эдийн засгийн идэвхжил нэмэгдэж, уул уурхайн бүтээгдэхүүний экспортын биет хэмжээ өссөн нөлөөгөөр төсвийн орлого нэмэгдэн төсвийн нийт тэнцэл 2024 оны эхний 3 улирлын байдлаар 2.5 их наяд төгрөгийн ашигтай гарсан хэдий ч нүүрсний үнийн бууралт АМНАТ-ийн орлогод сөрөг нөлөө үзүүлж байна.

Энэ онд шинээр байгуулагдсан хамтарсан Засгийн газар Монгол Улсын урт, дунд хугацааны бодлогын баримт бичигт тусгагдсан хөгжлийн тулгамдсан асуудлуудыг хурдтай шийдвэрлэх зорилтуудыг дэвшүүлж, Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулан хөрөнгө оруулалтын зардлыг 1.8 их наяд төгрөгөөр нэмэгдүүлснээр нийт төсвийн зарлага 2024 оны батлагдсан дүнгээс 11.4 хувиар нэмэгдээд байна.

Засгийн газрын нэрлэсэн дүнгээр илэрхийлсэн өрийн үлдэгдлийн ДНБ-д харьцуулсан харьцаа 2024 оны 3 дугаар улирлын байдлаар 38.9 хувьд хүрч нэмэгдсэн ба нийслэлийн гадаад болон дотоод зах зээлд гаргасан үнэт цаастай холбоотойгоор дунд хугацаанд Засгийн газрын өрийн хэмжээ нэмэгдэхээр байна.


25. Экспортын биет хэмжээ өссөн нь төсвийн орлогыг нэмэгдүүлж, төсвийн тэнцэл ашигтай гарах нөхцөлийг бүрдүүллээ. Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт орлого 2024 оны эхний 3 улиралд 22.3 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 26.6 хувиар өслөө. Харин нэгдсэн төсвийн зарлага 19.8 их наяд хүрч, өмнөх оны мөн үеэс 34.4 хувиар өссөнөөр нэгдсэн төсвийн нийт тэнцэл 2.5 их наяд төгрөг, тэнцвэржүүлсэн тэнцэл 1.5 их наяд төгрөг, үндсэн тэнцэл 3.5 их наяд төгрөгийн тус тус ашигтай гарлаа.

26. Эдийн засгийн идэвхжил өндөр байж, уул уурхайн бүтээгдэхүүний экспортын биет хэмжээ нэмэгдсэн нь ААНОАТ, НӨАТ-ын орлогыг нэмэгдүүллээ. Төсвийн тэнцвэржүүлсэн орлого 2024 оны эхний 3 улирлын гүйцэтгэлээр 21.3 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 26.0 хувиар өндөр төвлөрсөн байна. Уул уурхайн салбарын идэвхжил өндөр хэвээр хадгалагдаж, нүүрсний экспортын биет хэмжээ 2024 оны эхний 3 улиралд 61.2 сая тоннд хүрч, өмнөх оны мөн үеэс 25.2 хувиар

өссөн нөлөөгөөр тус салбарын аж ахуй нэгжүүдийн орлого өсөж, улмаар ААНОАТ-ын орлого 4.8 их наяд төгрөгт хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 50.0 хувиар өссөн байна. Мөн 2024 оны 2 дугаар улирлын эхэнд цалин, тэтгэвэр, тэтгэмжийг нэмэгдүүлсэн нь төрийн болон өрхийн хэрэглээг идэвхжүүлсэн байна. Үүний нөлөөгөөр НӨАТ-ын орлого 2024 оны эхний 3 дугаар улиралд 4.3 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 27 хувиар өслөө.

27. Түүхий эдийн экспортын биет хэмжээ өндөр байгаа ч үнийн бууралт АМНАТ-ийн орлогод сөргөөр нөлөөлж байна. АМНАТ-ийн орлого 2024 оны 3 дугаар улирлын байдлаар 3.6 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 11.5 хувиар буурлаа. АМНАТ-ийн орлогын дийлэнх нь уул уурхайн салбараас төвлөрдөг буюу нүүрс 70 хувь, зэсийн баяжмал 22 хувь, алт 4 хувь, төмрийн хүдэр 1 хувийг тус тус бүрдүүлж байна. Нүүрсний экспортын биет хэмжээ өссөн хэдий ч үнэ буурсан нь орлого буурахад гол нөлөө үзүүлээ.

Зураг 2.1. Төсвийн орлого, зарлага, тэнцэл



28. Суудлын автомашины импортын биет хэмжээ өндөр байсан нь онцгой албан татварын орлогод эерэг нөлөө үзүүлээ.

Суудлын автомашины тоо хэмжээ энэ 2024 оны 3 дугаар улирлын байдлаар 93.6 мянга хүрч, өмнөх оны мөн үеэс 75.8 хувиар өссөн нь онцгой албан татварын орлогын хэмжээг төсөвлөсөн хэмжээнээс 13.8 хувиар өсөхөд голлон нөлөөллөө.

29. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт (тодотгол) орууллаа.

Монгол Улсын Үндсэн хуульд 2023 оны 5 дугаар сарын 31-ний өдөр оруулсан өөрчлөлтөөр сонгуулийн холимог тогтолцоонд шилжиж, анхны 126 гишүүнтэй Улсын Их Хурал байгуулагдаж, ард иргэдийн сонгуулиар өгсөн саналыг орхигдуулахгүй байх зарчмыг үндэслэн анхны гурван намын хамтарсан Засгийн газрыг байгууллаа. Хамтарсан Засгийн газар “Алсын хараа-2050”, Монгол Улсын урт хугацааны бодлого, Шинэ сэргэлтийн бодлого, намуудын мөрийн хөтөлбөрт туссан онцлог заалтуудыг нэгтгэн хөгжлийн тулгамдсан асуудлуудыг хурдтай шийдвэрлэх, олон жил гацаад байсан бүтээн байгуулалтын томоохон төслүүдийг эрчимжүүлэх зорилтыг тавьж, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт орууллаа. Энэ хүрээнд 2024 оны төсвийн тухай хуульд урсгал зардлыг 1.2 их наяд төгрөгөөр, хөрөнгө оруулалтын зардлыг 1.8 их наяд төгрөгөөр тус тус нэмэгдүүлж, нийт зарлага анх батлагдсан дүнгээс 11.4 хувь, өнгөрсөн оны мөн үеэс 35.4 хувиар нэмэгдэн 30.5 их наяд төгрөг байхаар өөрчлөлт оруулан баталлаа.

30. Инфляцын түвшинтэй уялдуулан цалин, тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлсэн нөлөөгөөр төсвийн зарлага тэлж, өрхийн бодит орлогыг сайжирлаа.


Төсвийн нийт зарлага 2024 оны 3

улирлын байдлаар 19.8 их наяд төгрөгт хүрч өнгөрсөн оны мөн үеэс 5.1 их наяд төгрөг буюу 34.4 хувиар өссөн байна. Нийт зардлын өсөлтөд урсгал зардлын өсөлт 3.7 их наяд (25.3 нэгж хувь) төгрөг, хөрөнгийн зардал 1.1 их наяд (7.7 нэгж хувь) төгрөг, эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл 0.2 их наяд (1.4 нэгж хувь) төгрөгийг тус тус бүрдүүлж байна. Засгийн газраас өрхийн орлогыг дэмжих хүрээнд тэтгэвэр, тэтгэмж, төрийн албан хаагчдын цалин хөлсийг 2024 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн инфляцын түвшинтэй уялдуулан дунджаар 10 хувиар нэмэгдүүлж, цалингийн зардал өнгөрсөн оны мөн үеэс 2.2 их наяд төгрөг буюу 2.4 дахин, тэтгэвэр, тэтгэмжийн зардал 31.6 хувиар тус тус нэмэгдсэн нь урсгал зардлын өсөлтөд голлох нөлөө үзүүлээ. Цалин хөлс, тэтгэвэр тэтгэмжийн хэмжээг нэмэгдүүлсэн нөлөөгөөр өрхийн сарын дундаж бодит орлого энэ оны 3 дугаар улирлын байдлаар 10 хувиар нэмэгдэж, дундаж нэрлэсэн орлого 2.6 сая төгрөгт хүрлээ.

31. Барилга байгууламжийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэл өмнөх оны мөн үеэс удаашралтай байна.

Нэгдсэн төсвийн хөрөнгө оруулалтын өссөн дүнгээрх санхүүжилтийн гүйцэтгэл 2024 оны 3 дугаар улирлын байдлаар 4.0 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 2.4 дахин нэмэгдэж, нийт хөрөнгө оруулалт гүйцэтгэл 49 хувьтай байна. Эдийн засгийн ангиллаар харвал их засварын гүйцэтгэл 97.0 хувь, стратегийн нөөц хөрөнгө 58.3 хувь, тоног төхөөрөмж 60.0 хувь, бусад хөрөнгө 51.0 хувьд хүрч өмнөх оны мөн үеэс сайжирсан бол барилга байгууламж 46.0 хувийн гүйцэтгэлтэй буюу өмнөх оны мөн үеэс 20.6 нэгж хувиар буурсан байна. Төсвийн тодотголоор барилгын хөрөнгө оруулалтын төсөвт өртгийг 1.0 их наяд төгрөгөөр нэмэгдүүлсэн нь барилга байгууламжийн хөрөнгө оруулалтын зардлын гүйцэтгэл удааших гол шалтгаан болсон

Зураг 2.2. Төсвийн зарлага



байна. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн тухай хуульд 2024 оны 8 дугаар сарын 30-ны өдөр өөрчлөлт оруулж, улсын төсвийн хөрөнгө оруулалтын бодлогыг хөгжлийн бүтээн байгуулалтын томоохон төслүүдийг эхлүүлэх, ТЭЗҮ, зураг төсвийн санхүүжилтийг төсөвт тусгаж, төсвийн хөрөнгө оруулалтыг бүсчилсэн хөгжил, Улаанбаатар хотын төвлөрлийг сайруулах, түгжрэлийг бууруулахаар төлөвлөсөн бөгөөд цаашид хөрөнгө оруулалтын санхүүжилтийг хөгжлийн томоохон бүтээн байгуулалт руу чиглүүлнэ.

32. Эрчим хүчний салбар болон нийтийн тээврийн алдагдалд олгох татаас нийт татаасны дийлэнх хувийг бүрдүүлж байна. Нэгдсэн төсвөөс 2024 оны 3 дугаар улирлын байдлаар нийт 648.8 тэрбум төгрөгийн татаасыг олгосон бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулахад 69.7 хувиар өссөн байна. Өмчийн хэлбэрээр харвал төрийн өмчит байгууллагад 252.9 тэрбум төгрөг (39.0 хувь), хувийн хэвшлийн байгууллагад 395.9 тэрбум төгрөг (61.0 хувь)-ийн татаасыг тус тус олгосон байна. Төсвийн зардалд нийт татаасны эзлэх хувь 3.3 хувьд хүрч

өмнөх оны мөн үеэс 0.7 нэгж хувиар өссөн байна. Тодруулбал, эрчим хүчний салбарт болон нийтийн тээврийн байгууллагуудын алдагдалд олгох татаасны хэмжээ 2024 оны 3 дугаар улирлын байдлаар нийт татаасны 62 орчим хувийг бүрдүүлж байна. Үүнээс нийтийн тээврийн алдагдалд олгосон татаас 200.0 тэрбум төгрөг өмнөх оны мөн үеэс 78 хувиар, эрчим хүчний алдагдалд олгох татаас 200.0 тэрбум өмнөх оны мөн үеэс ойролцоогоор 3 дахин тус тус өссөн байна. Хөдөө аж ахуйн салбарын бүтээгдэхүүн, үйлдвэрлэлийг дэмжих урамшуулалд 2024 оны 3 дугаар улиралд 153.5 тэрбум төгрөгийг олгосон нь өмнөх оны мөн үеэс мөн 3 дахин өссөн үзүүлэлтэй байна. Хэдийгээр манай улсын хувьд нэгдсэн төсвийн зардлын гүйцэтгэлд нийт татаасны эзлэх хувь сүүлийн 10 жилийн байдлаар 2-3 хувь байгаа хэдий ч цаашид төсвийн зардлыг бууруулах чиглэлд эрчим хүчний салбарын иж бүрэн шинэчлэлийг хэрэгжүүлэх, нийтийн тээврийн салбарыг хувьчлах, үр ашиггүй татаас олгох тогтолцоог зогсоож, эх үүсвэрийг илүү үр ашигтай хөрөнгө оруулалт руу шилжүүлэх нь чухал байна.

ТӨСВИЙН БОДЛОГЫН ТӨЛӨВ


33. Эдийн засгийн идэвхжил төсвийн нийт тэнцэл ашигтай гарахад чухал нөлөө үзүүлээ.

Төсвийн бодлогын цэвэр нөлөөг үнэлэхдээ төсвийн тэнцэлд үзүүлэх улирлын болон мөчлөгийн нөлөөг арилгаж тооцох нь оновчтой аргачлал болдог. Улирлын нөлөө нь эдийн засгийн идэвхжилд цаг хугацааны давтамжтайгаар илрэх нөлөөллийг харуулдаг бол мөчлөгийн нөлөө нь зах зээлийн өсөлт, уналтаас хамаарсан, цаг хугацааны тогтмол бус нөлөөллийг илэрхийлдэг. Тухайлбал дулааны улиралд худалдаа, үйлчилгээний салбар идэвхжиж, жуулчдын тоо өссөн нь эдийн засгийн үзүүлэлтэд эергээр нөлөөлж, НӨАТ-ын орлогыг нэмэгдүүлснээр төсвийн нийт тэнцэл 3 дугаар улиралд (тухайн улирлын дүнгээр) 492 тэрбум төгрөгийн ашигтай гарахад чухал нөлөө үзүүлээ.

34. Улирлын нөлөө арилгасан нийт тэнцэл 110 тэрбум төгрөгийн алдагдалтай байна. Төсвийн

алдагдалд нөлөөлөх төсвийн бодлогоос шалтгаалах нөлөөг төсвийн төлөвөөр, төсвийн бодлогоос үл хамаарах эдийн засгийн мөчлөгийн нөлөөг автомат тогтворжуулагчаар, өрийн дарамтыг хүүгийн зардлаар тус тус илэрхийлэн зураг 2.3-т харуулав. Төсвийн үндсэн тэнцэл ашигтай байгаатай холбоотойгоор төсвийн төлөв 421 тэрбум буюу потенциал ДНБ-ий 2 хувьтай тэнцэх дүнгээр улирлын нөлөө арилгасан төсвийн нийт тэнцэлд эерэг нөлөө үзүүлсэн бол хүүгийн төлбөр 363 тэрбум буюу потенциал ДНБ-ий 1.8 хувьтай тэнцэх дүнгээр төсөвт дарамт учруулсан байна. Үйлдвэрлэлийн сөрөг зөрүү хаагдсан хэдий ч эдийн засгийн идэвхжилийн хурд саарч, түүхий эдийн үнийн уналт төсвийн орлого бүрдэлтэд сөрөг нөлөө үзүүлснээр төсвийн бодлогоос үл хамаарах мөчлөгийн нөлөө 168 тэрбум буюу ДНБ-ий 0.8 хувьтай тэнцэх хэмжээнд төсвийн тэнцэлд сөрөг нөлөө үзүүлээ.

Зураг 2.3. Төсвийн тэнцэл, төсвийн төлөв, автомат тогтворжуулагч



ЗАСГИЙН ГАЗРЫН ӨРИЙН ТОГТВОРТОЙ БАЙДАЛ

35. Засгийн газрын өрийн нэрлэсэн хэмжээ өмнөх оны мөн үеийн түвшинд хүрч нэмэгдлээ. Гадаад бонд болон гадаад зээлийн эргэн төлөлттэй холбоотойгоор 4 улирал дараалан буураад байсан Засгийн газрын өр сүүлийн 2 улирал дараалан өсөж, 2024 оны 3 дугаар улиралд өмнөх оны мөн үеийн түвшин буюу 30.8 их наяд төгрөгт хүрлээ. Орон нутгийн зээллэг он гарснаас хойш 513.5 тэрбум төгрөгөөр өссөн бөгөөд Засгийн газрын өрийн баталгааны хэмжээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 535.5 тэрбум төгрөг буюу 72 хувиар буурсан ч энэ оны эхний улирлаас 179.1 тэрбум төгрөгөөр буюу 6.1 дахин өссөн үзүүлэлтэй байна. Харин Засгийн газрын дотоод өр өмнөх оны мөн үеэс 437.3 тэрбум төгрөгөөр, энэ оны эхний улирлаас 99.8 тэрбум төгрөгөөр тус тус буурсан байна.

36. Нийгэм, дэд бүтцийн шинж чанартай төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх зорилготой нийслэлийн дотоод, гадаад бонд нь Засгийн газрын өрийг нэмэгдүүлэх төлөвтэй байна. Засгийн газрын 2024 оны 5 дугаар сарын 8-ны өдрийн 201 дүгээр тогтоол болон 6 дугаар сарын 6-ны өдрийн 264 дүгээр тогтоолын хүрээнд 2024 онд дэд бүтцийн шинж чанартай төслүүдийг санхүүжүүлэх зорилгоор 1.0 их наяд төгрөгийн үнэт цаасыг дотоодын зах зээлд арилжаалахаар шийдвэрлэсэн. Энэхүү шийдвэрийн дагуу 2024 оны 6 дугаар сарын 25-ны өдөр 500 тэрбум төгрөгийн үнэт цаасыг арилжаалсан. Түүнчлэн дотоодын зах зээлд дахин 500 тэрбум төгрөг, гадаадын зах зээлд 500 сая ам.долларын бонд арилжаалж, “Сэлбэ дэд төвд түшиглэсэн гэр хорооллыг орон сууцжуулах төсөл”,


Зураг 2.4. Засгийн газрын өр

1. Засгийн газрын өр
(зүүн тэнхлэг: их наяд төгрөг, баруун тэнхлэг: хувь)




Эх сурвалж: Сангийн яам

2. Засгийн газрын өрийн задаргаа
(зүүн тэнхлэг: их наяд төгрөг, баруун тэнхлэг: хувь)



Эх сурвалж: Сангийн яам

3. Засгийн газрын гадаад өрийн эргэн төлөлтийн хуваарь
(сая ам.доллар)



Эх сурвалж: Сангийн яам

Тайлбар: Засгийн газрын гадаад өр нь гадаад үнэт цаас, гадаад зээлээс бүрдэнэ.

“Бөөрөлжүүтийн ДЦС”, “Батарей хуримтлуурын станц”, “Авто зам, замын байгууламжийн засвар, шинэчлэлтийн ажил”, “Ариутгах Бохир усны Туул-1 коллектор болон үерийн байгууламж” зэрэг төслүүдийг тус тус санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.

37. Засгийн газрын нийт өрд гадаад өрийн эрсдэл давамгай байна. 2024 оны 3 дугаар улирлын байдлаар Засгийн газрын нийт өрийн 97.3 хувийг гадаад өр бүрдүүлж байгаа нь Засгийн газрын өрийг ханшийн шок болон бусад гадаад орчны нөлөөнд мэдрэг болгож байна. Гадаад зээлийн 54.2 хувь нь ам.доллараар илэрхийлэгдсэн зээл байгаа бөгөөд төгрөгийн ам.доллартой харьцах ханшийн өөрчлөлт нь хүүгийн төлбөрийн дарамтыг нэмэгдүүлэх, мөн дахин санхүүжилтийн зардлыг өсгөх эрсдэл дагуулж болзошгүй байна. Мөн Засгийн газар 2025-2028 оны хооронд нийт 3.4 тэрбум ам.долларын гадаад зээл болон үнэт цаасны эргэн төлөлт хийх хуваарьтай байгаа нь ойрын жилүүдэд өрийн удирдлагад анхаарах шаардлагатай байгааг харуулж байна.


38. Засгийн газрын өрийн дунд хугацааны төлөвт үндсэн тэнцлийн нөлөө өндөр байна. Өрийн тогтвортой байдлын шинжилгээгээр Засгийн газрын өрийн дунд хугацааны төлөв макро эдийн засгийн голлох үзүүлэлтүүдэд хэр мэдрэг байгааг харуулах боломжтой. Тус тооцооллоор голлох үзүүлэлтүүдийн тухайлсан нөлөөг үнэлэх үүднээс 1) бодлогын болон бүтцийн өөрчлөлт байхгүй; 2) шокийн нөлөө тооцсон хувьсагчаас бусад хувьсагчийг тогтмол; 3) шокийн нөлөө тооцсон оноос бусад онд суурь түвшин өөрчлөгдөхгүй

гэж үзэв. Суурь төсөөллөөр 2024-2027 онуудад харгалзан ДНБ-ий өсөлт 5.6, 8.0, 6.5, 6.5 хувьд, инфляц 6.5, 7.5, 5.0, 4.0 хувьд, ханшийн сулрал сүүлийн 10 жилийн дундаж түвшинд, үндсэн тэнцэл төсөөллийн орчимд бусад макро үзүүлэлтүүд 2023 оны түвшинд тогтвортой байхад 2027 онд Засгийн газрын өр ДНБ-ий 42.7 хувьтай тэнцэхээр байна. Голлох үзүүлэлтүүдэд 2025, 2026 онуудад 1 стандарт хазайлт бүхий шок тооцоход, шокийн нөлөөгөөр 2027 онд Засгийн газрын өр суурь түвшнээс 15.4-28.8 хувиар өсөх магадлал харгалзан 25% байна. Энэ нь макро эдийн засгийн тодорхойгүй байдал, шокийн нөлөөнөөс Засгийн газрын өр өндөр мэдрэг болохыг харуулж байна.

39. Засгийн газрын өрийн тогтвортой байдлыг хангахад үндсэн тэнцлийг ашигтай түвшинд байлгах нь чухал байна. Засгийн газрын өрд нөлөөлөгч хүчин зүйлсийг өрийн динамик шинжилгээгээр үнэлж, зураг 2.7-д үзүүлэв. Засгийн газрын нэрлэсэн өрийн ДНБ-д эзлэх хэмжээ 2016 онд 30.6 хувиар өссөн бөгөөд үүнд үндсэн тэнцлийн алдагдал 11.2 нэгж хувийг эзэлсэн байна. Харин 2020 онд нэрлэсэн өр 10.1 хувиар өсөхөд үндсэн тэнцлийн алдагдал 6.9 нэгж хувийг бүрдүүлжээ. 2023 онд Засгийн газрын нэрлэсэн өрийн ДНБ-д эзлэх хувь хэмжээ 15.8 хувиар буурахад бодит хүүгийн өөрчлөлт 6.4 нэгж хувийг, үндсэн тэнцлийн ашиг 4.3 нэгж хувийг тайлбарлаж байна. Цаашид Засгийн газрын өрийн тогтвортой байдлыг хангахад ДНБ-ий бодит өсөлт болон үндсэн тэнцлийн алдагдал голлох үүрэг гүйцэтгэхээр байна. Иймд цаашид макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангахад чиглэсэн бодлогын арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх нь чухал байна.


Зураг 2.5. Засгийн газрын өрийн тогтвортой байдал

1. Засгийн газрын өрд үзүүлэх нэрлэсэн гадаад хүүгийн болон ханшийн сөрөг шокийн нөлөө (ДНБ-д эзлэх хувь)



Эх сурвалж: ЭЗХЯ-ны тооцоолол

2. Засгийн газрын өрд нөлөөлөгч хүчин зүйлс (өөрчлөлтөд эзлэх хувь)



Эх сурвалж: ЭЗХЯ-ны тооцоолол

БҮЛЭГ 3

МӨНГӨНИЙ СЕКТОР

3.1 Инфляц

3.2 Мөнгө ба санхүүгийн салбар

3. МӨНГӨНИЙ СЕКТОР

ТОЙМ

Инфляц 2024 оны 3 дугаар улирлын эцэст 6.7 хувьд хүрч, төв банкны зорилтот түвшинд хадгалагдлаа. Эдийн засгийн идэвхжилээс үүдэлтэй эрэлтийн гаралтай инфляц өсөж, дотоодын бараа, үйлчилгээний үнийн өсөлт өмнөх улирлаас эрчимжсэн бол импортын барааны инфляц тогтвортой хадгалагдав. Арилжааны банкуудын зээлийн өсөлт сүүлийн 10 жилийн дээд түвшинд хүрч эрчимжиж, мөнгөний нийлүүлэлтийн өсөлтөд голлох нөлөө үзүүлээ. Зээлийн өсөлт болон төсвийн тэлэлт өндөр байгаа энэ үед мөнгөний бодлогын хүүг 10 хувь болгож бууруулсан нь эрэлтийн гаралтай инфляцын дарамтыг нэмэгдүүлэх нөлөөтэй байж болзошгүй.

40. Инфляц өмнөх оны мөн үеэс буурч, төв банкны зорилтот түвшинд хадгалагдлаа.

Инфляц 2024 оны 9 дүгээр сард 6.7 хувьд хүрч, өмнөх оны мөн үеэс 3.4 нэгж хувиар буурлаа. Инфляцын 2.2 нэгж хувийг хүнсний бараа, 1.0 нэгж хувийг хувцас, бөс бараа, гутлын бүлэг, 0.9 нэгж хувийг боловсролын үйлчилгээ, 0.7 нэгж хувийг орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлш бүрдүүллээ. Инфляц өнгөрсөн оны мөн үеэс буурсны 2.4 нэгж хувийг хүнсний бараа, 0.6 нэгж хувийг хувь хүнд хандсан үйлчилгээ, 0.3 нэгж хувийг нийтийн хоолны үйлчилгээ бүрдүүлсэн бол хувцас, бөс бараа, гутал, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлш, боловсролын үйлчилгээний үнэ инфляцыг өсгөх нөлөө үзүүлжээ.

41. Эдийн засгийн идэвхжил хадгалагдсанаар нийт инфляцын дийлэнх хэсгийг эрэлтийн гаралтай инфляц бүрдүүлээ.


Эрэлтийн (суурь) инфляц 6.6 хувьд хүрч, өмнөх улиралтай харьцуулахад 1.4 нэгж хувиар эрчимжлээ. Тэтгэвэр, тэтгэмж, төрийн албан хаагчдын цалин нэмэгдэн өрхийн хэрэглээ өсөж, дотоод эрэлтийн идэвхжил хадгалагдсанаар эрэлтийн инфляц нийт инфляцын дийлэнх буюу 66 орчим хувийг бүрдүүлэв. Нийлүүлэлтийн гаралтай

инфляц 6.9 хувь болж, өмнөх улирлаас 2.1 нэгж хувиар өссөн байна. Үүнд өвөлжилт, хаваржилт хүндэрч, мал ихээр хорогдсоны улмаас махны нийлүүлэлт буурч, махны үнэ улирлын хандлагаасаа өндрөөр өссөн нь нөлөөлжээ. Мөн түлшний модны үнэ өссөн нь нийлүүлэлтийн инфляцыг өсөхөд нөлөөлсөн байна.

42. Импортын бараа, бүтээгдэхүүний инфляц тогтвортой байсан бол дотоодын бараа, үйлчилгээний инфляц өсөх хандлагатай байв.

Өмнөх оны мөн үед 7.6 хувь байсан импортын инфляц 2024 оны 9 дүгээр сард 4.8 хувь болж, нийт инфляцын 32.8 хувийг бүрдүүллээ. Импортын гаралтай инфляцын 95 гаруй хувийг хүнсний бус барааны үнийн өсөлт тайлбарлаж байна. Худалдааны түнш орнуудын бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлт саарснаар импортын инфляц тогтвортой хадгалагдлаа. Харин нийт инфляцын 67.2 хувийг бүрдүүлж буй дотоодын бараа, үйлчилгээний инфляц 2024 оны 9 дүгээр сард 8.3 хувь болж, өмнөх оны мөн үеэс 3.9 нэгж хувиар буурсан ч өмнөх улирлаас эрчимжлээ. Дотоодын бараа, үйлчилгээний инфляц өмнөх оны мөн үеэс саарахад дотоодын зарим хүнсний үнийн өсөлт саарсан нь голлон нөлөөлсөн

Зураг 3.1. Инфляцын бүрэлдэхүүн



байна. Харин өмнөх улирлаас эрчимжихэд мах, махан бүтээгдэхүүн, орон сууцны бодит түрээс, боловсролын үйлчилгээний үнийн өсөлт голлох нөлөө үзүүлээ.

43. Олон улсад чингэлэг тээврийн үнэ болон хүнсний үнийн индекс өмнөх оны мөн үеэс өслөө. Дэлхийн чингэлэг тээврийн үнэ Улаан тэнгис дэх Суэцийн сувагт үүссэн халдлагын нөлөөгөөр 2024 оны 2 дугаар сараас хойш эрчтэй өсөөд байсан бол 8 дугаар сараас аажмаар буурч эхэлсэн байна. Дэлхийн чингэлэг тээврийн үнэ 2024 оны 3 дугаар улирлын эцсийн байдлаар 40 фут чингэлэг тутам 3691 ам.доллар болж буурчээ. Энэ нь өмнөх оны мөн үеэс 163 хувиар, цар тахлын өмнөх үеэс 160 хувиар өндөр үзүүлэлт юм. Хүнсний үнийн индекс 2024 оны 9 дүгээр сард 124.6 болж, өмнөх оны мөн үеэс 2.1 хувиар өсөж, 2023 оны 4 дүгээр сараас хойших хамгийн өндөр түвшинд хүрлээ. Дэлхийн зах зээл дээр үр тариа, сүүн бүтээгдэхүүн, ургамлын тос, элсэн чихрийн үнэ өсөж, махны үнэ буурсан байна. Дэлхий дахинд инфляц буурах хандлага үргэлжилж, хөгжингүй болон хөгжиж буй орнуудын инфляц төв банкны зорилтот түвшин рүү ойртсоор байна. Сүүлийн сард БНХАУ, ОХУ, Казакстан, Киргизстан, Турк, Шри-Ланк улсуудын инфляц буурсан бол Солонгос, Гүрж, Евро бүс, Америк, Их Британи улсуудын инфляц өсжээ.


44. Хүнсний ба хүнсний бус бараа, үйлчилгээний инфляц өмнөх улирлаас эрчимжив. Хүнсний барааны инфляц 2024 оны 3 дугаар улирлын байдлаар 7.7 хувьд хүрч, өмнөх улиралтай харьцуулахад 0.8 нэгж

хувиар нэмэгдлээ. Нийт инфляцын 2.2 нэгж хувийг бүрдүүлсэн хүнсний инфляц өмнөх улирлаас өсөхөд махны үнэ 12.1 хувиар өссөн нь томоохон нөлөөг үзүүлээ. Мөн гурил, гурилан бүтээгдэхүүний үнэ жилийн 5.7-6 хувиар, сүүн бүтээгдэхүүн, өндөгний үнэ 9.2 хувиар өссөн нь нөлөөлсөн байна. Түүнчлэн, хүнсний бус бараа, үйлчилгээний инфляц 6.0 хувь хүрч, өмнөх улирлаас 0.9 нэгж хувиар өслөө. Хүнсний бус инфляцад хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ 8.2 хувиар, түлшний модны үнэ 14.6 хувиар тус тус өссөн болон зарим үйлчилгээний үнэ өсөлттэй байсан нь нөлөөлөв. Тухайлбал, хувь хүнд хандсан үйлчилгээний үнэ 11.7 хувиар, орон сууцны бодит түрээс 23 хувиар, боловсролын үйлчилгээний үнэ 18.2 хувиар өссөн байна.


45. Бодлогын хүү зохистой түвшнээс бага байна. Төв банк 2024 онд бодлогын хүүг 3 нэгж хувиар бууруулж, 10 хувьд хүргэсэн ба 2024 оны 3 дугаар улирлын бодлогын хүүний дундаж түвшин 10.7 хувь байна. Бодлогын хүүний дундаж түвшин нь бодлогын хүүний зохист утгыг илэрхийлэх Тэйлорын дүрмээр тооцсон хүүний түвшнээс 1 нэгж хувиар доогуур гарснаар бодлогын хүүг бууруулах орон зай хумигдлаа. Түүнчлэн, 2024 оны 3 дугаар улирлаас эхлэн бодит хүүний зөрүү мөнгөний нөхцөлийг сулруулах нөлөө үзүүлж эхэллээ. Зээлийн өсөлт, төсвийн тэлэлт, геополитикийн тогтворгүй байдал, тээвэр логиستيкийн саатал, өвөлжилт, хаваржилтын хүндрэл зэрэг инфляцыг өсгөх эрсдэлүүд өндөр байгаа тул бодлогын хүүг зохистой түвшинд хадгалах шаардлагатай байна.

Зураг 3.2. Тэйлорын хүү, мөнгөний нөхцөлийн индекс

1. Бодлогын хүү ба Тэйлорын хүү (хувь)



2. Мөнгөний нөхцөлийн индекс (хувь)




Эх сурвалж: ЭЗХЯ-ны тооцоолол
Тэмдэглэл: Тэйлорын дүрмээр тооцсон хүү нь бодлогын хүүний зохистой утгыг илэрхийлэх бөгөөд өмнөх улирлын бодлогын хүү, инфляц, инфляцын хүлээлт, нэрлэсэн хүү зэрэг хувьсагчид болон тогтмол коэффициентийг агуулсан тэгшитгэл юм. ЭЗХЯ-ны үйлдвэрлэлийн зөрүүг тооцох аргачлал шинэчлэгдсэнтэй холбоотойгоор өмнөх улирлуудын Тэйлорын дүрмээр тооцсон хүүг шинэчилж тооцоолов.


Эх сурвалж: ЭЗХЯ-ны тооцоолол
Тэмдэглэл: Мөнгөний нөхцөлийн индекс нь эдийн засаг дахь мөнгөний бодлогын нөлөөг хэмжих үзүүлэлт юм. Мөнгөний нөхцөлийн индексийг Мөнгөний бодлогын шинжилгээний GAP арга зүйг ашиглан тооцоолов. Тус индекс эерэг буюу 0-ээс их байвал мөнгөний хатуу бодлогын төлөвийг, сөрөг утга нь мөнгөний бодлого сул байгааг илтгэдэг.

Зураг 3.3. Голлох бүтээгдэхүүний үнэ


1. Хонины мах (кг/төгрөг)




2. Үхрийн мах (кг/төгрөг)




3. Гурил, 1-р зэрэг (кг/төгрөг)




4. Талх, Атар (төгрөг)




5. Ургамлын тос (төгрөг)




6. Төмс (төгрөг)



7. Сүү, савласан (литр/төгрөг)



8. Дизель түлш (литр/төгрөг)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо
Тэмдэглэл: Голлох зарим бүтээгдэхүүний үнийн динамикийг сараар харуулав.

МӨНГӨ БА САНХҮҮГИЙН САЛБАР


46. Мөнгөний нийлүүлэлтийн өсөлт эрчимжив.

Мөнгөний нийлүүлэлтийн өсөлт 2024 оны 3 дугаар улиралд 25.9 хувьд хүрч, өмнөх оны мөн үеэс 4.9 нэгж хувиар өслөө. Эх үүсвэр талаас мөнгөний нийлүүлэлтийн өсөлтийн 17.3 нэгж хувийг төгрөгийн хадгаламж, 11.3 нэгж хувийг төгрөгийн харилцах, 0.4 нэгж хувийг хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө бүрдүүлсэн бол гадаад валютын хадгаламж ба харилцах 1.9 ба 1.2 нэгж хувиар бууруулах нөлөө үзүүлсэн байна. Төгрөгийн ханш 2023 оны 8 дугаар сараас чангарч, 2024 онд харьцангуй тогтвортой хадгалагдсан нь гадаад валютын харилцах, хадгаламж буурахад нөлөөллөө. Байршуулалт талаас мөнгөний нийлүүлэлтийн өсөлтийн 20.4 нэгж хувийг дотоод цэвэр актив, 5.5 нэгж хувийг гадаад цэвэр актив бүрдүүллээ. Дотоод цэвэр активын өсөлтөд банкнуудын зээлийн өсөлт эрчимжсэн нь голлон нөлөөлж байна.

47. Зээлийн өсөлт сүүлийн 10 жилийн дээд түвшинд хүрч эрчимжив.

Банкны салбарын зээлийн үлдэгдэл 2024 оны 3 дугаар улирлын байдлаар 35.0 их наяд төгрөг болж, жилийн өсөлт 35.2 хувьд хүрсэн нь сүүлийн 10 жилийн хамгийн өндөр өсөлт болов. Нийт зээлийн үлдэгдлийн 68 хувь буюу 23.8 их наяд төгрөгийг бизнесийн зээл, 32 хувь буюу 11.2 их наяд төгрөгийг хэрэглээний зээл бүрдүүлж байна. Бизнесийн зээлийн үлдэгдлийн өсөлт 2024 оны 3 дугаар улирлын байдлаар 34.2 хувьд хүрч, өсөлтийн хурд өмнөх оны мөн үеэс 5.6 дахин өссөн байна. Бизнесийн зээлийн өсөлтөд үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагааны зээл өмнөх оны мөн үеэс 46.4 хувиар, бөөний болон жижиглэн худалдааны зээл 22.2 хувиар, уул уурхай, олборлолтын зээл 51.6 хувиар, хөдөө аж ахуйн салбарын зээл 97.1 хувиар, боловсруулах үйлдвэрлэлийн 23.8 хувиар тус тус өсөж, голлох нөлөө үзүүлжээ. Харин хэрэглээний

Зураг 3.4. Мөнгөний нийлүүлэлт, зээлийн үзүүлэлтүүд



зээлийн үлдэгдлийн өсөлт 2024 оны 3 дугаар улирлын байдлаар 37.4 хувьд хүрсэн бөгөөд өсөлтийн хурд өмнөх оны мөн үеэс 2.9 нэгж хувиар өссөн ч 2024 оны эхнээс 3.9 нэгж хувиар саарсан байна. Хэрэглээний зээлийн өсөлтөд цалингийн зээл өмнөх оны мөн үеэс 50 хувиар, тэтгэврийн зээл 48.7 хувиар, хадгаламж барьцаалсан зээл 19.1 хувиар, өрхийн хэрэглээнд зориулсан зээл 66.7 хувиар өссөн нь голлон нөлөөлжээ.


48. Шинээр олгосон зээлийн өсөлт бизнесийн зээлийн хувьд эрчимжиж, хэрэглээний зээлийн хувьд саарав. Банкны салбарын шинээр олгосон зээл 2024 оны эхний 3 улирлын байдлаар 41.9 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 12.0 их наяд төгрөгөөр буюу 39.8 хувиар өслөө. Шинээр олгосон зээлийн жилийн өсөлт энэ оны эхний 3 улирлын байдлаар бизнесийн зээлийн хувьд 45.1 хувьд хүрч өмнөх оны мөн үеэс 23.8 нэгж хувиар эрчимжсэн бол хэрэглээний зээлийн хувьд 31.6 хувьд хүрч өмнөх оны мөн үеэс 7.1 нэгж хувиар саарлаа. Уул уурхай, бөөний болон жижиглэн худалдаа, санхүү, даатгалын үйл ажиллагаа, үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагааны салбаруудад зээл олголт нэмэгдсэн нь бизнесийн зээлийн өсөлтөд голлох нөлөө үзүүлэв.

49. Банкны салбарын зээлийн чанар сайжрахад уул уурхай, үл хөдлөх хөрөнгийн салбарууд эергээр нөлөөлөв. Чанаргүй зээлийн нийт хэмжээ 2024 оны 3 дугаар улирлын байдлаар 2.0 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 9.8 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Уг бууралтад уул уурхай, олборлолт, үл хөдлөх хөрөнгийн

үйл ажиллагааны салбарын чанаргүй зээл буурсан нь голчлон нөлөөлжээ. Нөгөө талаас, хэрэглээний буюу цалин, тэтгэвэр, өрхийн хэрэглээнд зориулсан зээлийн чанаргүй зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 13.5 хувиар нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь үргэлжлэн буурч, 5.7 хувь буюу сүүлийн 8 жилийн хамгийн бага түвшинд хүрлээ.

50. Иргэдийн болон байгууллагын төгрөгийн хадгаламж өсөв. Банкнуудын нийт хадгаламж 2024 оны 3 дугаар улирлын байдлаар 25.0 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 25.7 хувиар өслөө. Үүнээс иргэдийн хадгаламж 20.8 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 23.3 хувиар өссөн байна. Тодруулбал, иргэдийн төгрөгийн хадгаламж 17.6 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 34.9 хувиар өссөн бол иргэдийн валютын хадгаламж 3.3 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 16.0 хувиар буурлаа. Харин байгууллагын хадгаламж 4.2 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 39.2 хувиар өслөө. Байгууллагын төгрөгийн хадгаламж 3.0 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 65.1 хувиар өссөн бол валютын хадгаламж 1.2 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 0.4 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Төгрөгийн хадгаламжийн үлдэгдэлд жигнэсэн дундаж хүү 2024 оны 3 дугаар улирлын байдлаар 11.8 хувь байгаа бол валютын хадгаламжийн жигнэсэн дундаж хүү 3.7 хувьд хүрч, өмнөх оны мөн үеэс тус тус 0.5 нэгж хувиар өсжээ. Иргэд болон байгууллагын төгрөгийн хадгаламж өсөхөд хадгаламжийн хүү болон төгрөгийн ханшийн тогтвортой байдал нөлөөллөө.

Зураг 3.5. Хадгаламжийн жилийн өсөлтийн бүрэлдэхүүн, хүүгийн үзүүлэлтүүд



51. Бодлогын хүү буурснаар банк хоорондын захын жигнэсэн дундаж хүү буурлаа. Мөнгөний бодлогын хүү буурч, банк хоорондын захын жигнэсэн дундаж хүү 2024 оны 3 дугаар улиралд 10.2 хувь болж, өмнөх оны мөн үеэс 2.8 нэгж хувиар, өмнөх улирлаас 0.7 нэгж хувиар тус тус буурсан байна. Банк хоорондын захын жигнэсэн дундаж хүү бууралттай байсан хэдий ч шинээр татсан хадгаламжийн жигнэсэн дундаж хүү 11.5 хүрч, өмнөх оны мөн үеэс 0.5 нэгж хувиар өссөн байна.

52. Зээл болон хадгаламжийн бодит үйлчилж буй хүүгийн зөрүү өмнөх улирлаас өслөө. Арилжааны банкнуудын бодит үйлчилж буй зээлийн хүү 2024 оны 3 дугаар улиралд 17.7 хувь болж, өмнөх оны мөн үеэс 0.4 нэгж хувиар өсжээ. Бодит үйлчилж буй хадгаламжийн хүү 12 хувьд хүрч, өмнөх оны мөн үеэс 0.6 нэгж хувиар өссөн байна. Зээл ба хадгаламжийн бодит үйлчилж буй хүүгийн зөрүү 5.7 хувь гарч, өмнөх оны мөн үеэс 0.1 нэгж хувиар буурсан хэдий ч өнгөрсөн улиралтай харьцуулахад 1.0 нэгж хувиар өссөн байна. Бодлогын хүү бууралттай байгаа ч бодит үйлчилж буй хүүгийн зөрүү өмнөх улирлаас нэмэгдсэн байна.

53. Банк бус санхүүгийн байгууллагын зээлийн үлдэгдлийн өсөлт өндөр байна. 2024 оны 3 дугаар улиралд 555 банк бус санхүүгийн байгууллага үйл ажиллагаа явуулсан бөгөөд нийт зээлийн хэмжээ 5.2 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 53.9 хувиар өссөн байна. Нийт зээлийн үлдэгдлийн 89.7 хувийг иргэдэд, 10.3 хувийг хуулийн этгээдэд олгосон зээл бүрдүүлсэн бол нийт олгосон зээлийн 68 хувийг хэрэглээний зээл бүрдүүлжээ. 2024 оны 3 дугаар улиралд банк бус санхүүгийн байгууллагууд финтек зээлийн үйлчилгээгээр нийт 1.6 саяд зээлдэгчид 1.2 их наяд төгрөгийг олгосон байна. Банк бус санхүүгийн байгууллагуудын олгосон зээлийн жигнэсэн дундаж хүү сарын 3.4 хувьд хүрч, өмнөх оны мөн үеэс 0.1 нэгж хувиар өссөн байна.

54. Хөрөнгийн зах зээлийн үнэлгээ өмнөх оны мөн үеэс 17.6 хувиар өслөө. Хөрөнгийн зах зээлийн үнэлгээ 2024 оны 3 дугаар улиралд 12.1 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 17.6 хувиар өссөн байна. Хөрөнгийн зах зээлийн нийт үнэлгээ дотоодын нийт бүтээгдэхүүний 17.2 хувьтай тэнцэж байгаа бөгөөд банкнуудын анхдагч зах зээлд хувьцаа арилжаалж эхэлсэнтэй холбоотой сүүлийн жилүүдэд хөрөнгийн зах зээлийн үнэлгээ болон арилжааны идэвх сайжирч байна. Нийт үнэт цаасны арилжаа 2024 оны 3 дугаар улиралд 1.1 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 61.7 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Арилжааг төрлөөр нь задалбал 58.4 хувийг компанийн бонд, 23.1 хувийг хувьцаа, 12.4 хувийг хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас, 6.1 хувийг хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн арилжаа тус тус бүрдүүлжээ.

55. Үнэт цаасны зах зээлийн индексүүд өсөж, хөрвөх чадвар сайжирлаа. Хөрөнгийн зах зээлд 2024 оны 3 дугаар улиралд нийт 187 удаагийн 242.5 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий 895.4 сая ширхэг хувьцаа арилжаалагдсан бөгөөд 24.1 тэрбум төгрөгийн гүйлгээг анхдагч зах зээлийн арилжаа, 217.7 тэрбум төгрөгийн гүйлгээг хоёрдогч зах зээлийн арилжаа тус тус эзэлж байна. Мөн компанийн бондын арилжаа 618.7 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 6.4 дахин өсжээ. Нийт бондын арилжааны 80.8 хувийг 2024 оны 2 дугаар улиралд “Нийслэлийн засаг даргын хөтөлбөр”-ийн хүрээнд гаргасан өрийн хэрэгсэл эзэлж байгаа бөгөөд тайлант хугацаанд 2 компанийн шинэ бондын арилжаа бүртгэгдсэн байна. 2024 оны 3 дугаар улиралд ТОП-20 индексийн үзүүлэлт өмнөх оны мөн үеэс 35.1 хувиар өсжээ. Мөн MSE А болон MSE В индексүүд өмнөх оны мөн үеэс 20.4 ба 26.3 хувиар тус тус өссөн байна. Үнэт цаасны зах зээлийн хөрвөх чадварын харьцаа өмнөх оны мөн үеэс 0.5 нэгж хувиар нэмэгдэж, 1.8 хувь болсон байна.

БҮЛЭГ 4

ГАДААД СЕКТОР

- 4.1 Гадаад худалдаа
- 4.2 Төлбөрийн тэнцэл
- 4.3 Гадаад өр

4. ГАДААД СЕКТОР

ТОЙМ

Нүүрс, зэсийн баяжмал, төмрийн хүдэр зэрэг голлох уул уурхайн бүтээгдэхүүний биет хэмжээ нэмэгдсэн ч нүүрсний үнэ буурсан нь экспортын орлогын өсөлтийг хязгаарлалаа. Эдийн засгийн идэвхжилийг дагасан хөрөнгө оруулалт, хэрэглээний бараа, бүтээгдэхүүний импортын өсөлт өндөр хадгалагдлаа. Импортын өсөлт болон төв банкны своп хэлцлийн төлбөр гадаад валютын гарах урсгалыг нэмэгдүүлснээр 2024 оны 3 дугаар улиралд гадаад валютын нөөцийн өсөлтийн хурд саарч, төгрөгийн нэрлэсэн үйлчилж буй ханш суларлаа.

56. Голлох уул уурхайн бүтээгдэхүүний биет хэмжээ нэмэгдсэн ч нүүрсний үнэ буурлаа.

Экспорт 2024 оны 3 дугаар улирлын байдлаар 11.7 тэрбум ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 4.3 хувиар өслөө. Өсөлтөд нүүрс, зэсийн баяжмал, төмрийн хүдрийн экспортын биет хэмжээ нэмэгдсэн нь голлон нөлөөллөө. Нүүрсний экспортын биет хэмжээ 2024 оны 3 дугаар улирлын байдлаар 61.2 сая тоннд хүрч, өмнөх оны мөн үеэс 25 хувиар өссөн ч хилийн үнэ 18 хувиар буурлаа. Цаашид нүүрс, зэсийн баяжмалын экспортын биет хэмжээний өсөлт, дэлхийн зах зээл дээрх цэвэр зэс болон алтны үнийн өсөлт экспортын орлогын өсөлтийг дэмжихээр байна.

57. Зэсийн баяжмал, төмрийн хүдрийн экспорт нэмэгдлээ.

Оюутолгойн далд уурхайн нөлөөгөөр зэсийн баяжмалын экспорт 2024 оны 3 дугаар улирлын байдлаар 1,186 мянган тоннд хүрч өмнөх оны мөн үеэс 3 хувиар өслөө. Түүнчлэн, олборлолт нэмэгдсэнтэй холбоотойгоор төмрийн хүдрийн экспортын биет хэмжээ 5,466 мянган тоннд хүрч, өмнөх оны мөн үеэс 29 хувиар өссөн байна. Цаашид зэсийн баяжмал, төмрийн хүдрийн олборлолт тогтвортой нэмэгдэх, дэлхийн зах зээл дэх цэвэр зэсийн үнэ өсөхөөр байна.

58. Өвөлжилт, хаваржилт хүндэрсний улмаас хөдөө аж ахуйн гаралтай түүхий эдийн экспорт буурлаа.

Нийт нутгийн ихэнх хэсэгт өвөлжилт, хаваржилт хүндэрсэн нь хөдөө аж ахуйн гаралтай түүхий эдийн экспортод сөргөөр нөлөөлж, 2024 оны 3 дугаар улирлын байдлаар өмнөх оны мөн үетэй харьцуулахад махны экспорт 28 хувиар, ноолуурын экспорт 2 хувиар, арьс ширний экспорт 24 хувиар тус тус буурлаа.

59. Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжааны идэвх 2024 оны 3 дугаар улиралд суларлаа.

Уул уурхайн бүтээгдэхүүний биржээр 2024 оны эхний 9 сард нийт 17.8 сая тонн нүүрсийг 2.1 тэрбум ам.доллараар, 1,779 мянган тонн төмрийн хүдэр, баяжмалыг 125 сая ам.доллараар, 5.4 мянган тонн зэсийн баяжмалыг 12 сая ам.доллараар, 15.4 мянган тонн хайлуур жоншны хүдэр, баяжмалыг 2.4 сая ам.доллараар тус тус арилжаалаад байна. Уул уурхайн бүтээгдэхүүний биржээр 2024 оны эхний улиралд 127 арилжаа, 2 дугаар улиралд 212 арилжаа амжилттай хийгдсэн бол 3 дугаар улиралд арилжааны тоо 112 болж буурлаа. Тэр дундаа нүүрсний арилжааны тоо 2024 оны 5 дугаар сард 55 хүрснээс хойш 9 дүгээр сард 12 болж буурсан байна.

Зураг 4.1. Экспорт



60. Эдийн засгийн өсөлт хадгалагдаж, бараа, бүтээгдэхүүний импортын хэмжээг өсгөлөө.

Эдийн засаг 10 улирал дараалан өсөж, дотоод идэвхжил нэмэгдсэнээр импорт 2024 оны 3 дугаар улирлын байдлаар 8.6 тэрбум ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 27.4 хувиар өслөө. Үндэсний статистикийн хорооны салбар хоорондын тэнцлийн статистикт нийт импортыг үйлдвэрлэлийн завсрын хэрэглээ, эцсийн хэрэглээ болон хөрөнгийн хуримтлал гэж ангилдаг бөгөөд нийт импортын 60 орчим хувь нь үйлдвэрлэлд ашиглагддаг. (Зураг 4.2).

61. Импортын өсөлтийг барааны бүлгээр авч үзвэл: нийт өсөлтийн 12.4 нэгж хувийг хөрөнгө оруулалтын зориулалттай машин механик, тоног төхөөрөмж, барилгын материал, 10.2 нэгж хувийг хэрэглээний бүтээгдэхүүн, 4.8 нэгж хувийг нь аж үйлдвэрийн орц тус тус бүрдүүлсэн байна.

62. Уул уурхайн салбарын үйлдвэрлэлийн завсрын бүтээгдэхүүний импорт өслөө. Энэ оны эхний 3 улирлын байдлаар нүүрсний олборлолт 29 хувиар, экспортын биет хэмжээ 25 хувиар тус тус өссөн нь уул уурхайн салбарт ашиглагддаг завсрын бүтээгдэхүүний импортыг нэмэгдүүллээ.

Тухайлбал, экскаватор, шанагт ухагчийн импорт 264 сая ам.долларт хүрч өмнөх оны мөн үеэс 2 дахин, ачаа бараа тээвэрлэх тээврийн хэрэгсэл 570 сая ам.долларт хүрч 85 хувиар, дизель түлш 990 сая ам.долларт хүрч 23 хувиар тус тус өссөн байна.

63. Хэрэглээний бүтээгдэхүүний импортын өсөлтөд суудлын автомашины өсөлт голлох нөлөөг үзүүллээ. Хэрэглээний бүтээгдэхүүний импортын өсөлтөд удаан эдэлгээтэй бараа, бүтээгдэхүүн, тэр дундаа суудлын автомашины импортын өсөлт голлон нөлөөллөө. Иргэдэд шинээр олгосон зээл энэ оны 3 дугаар улирлын байдлаар 37.3 хувиар өссөн нь удаан эдэлгээтэй бараа, бүтээгдэхүүний импорт өсөхөд нөлөөлсөн бөгөөд энэ оны 3 дугаар улирлын байдлаар суудлын автомашины импорт 93.6 мянгад хүрч өмнөх оны мөн үеэс 75.8 хувиар нэмэгдсэн байна. Өнгөрсөн оны эхний 3 улиралд моторын багтаамж 3501 см³-ээс их том оврын суудлын автомашины импортын өсөлт өндөр байсан бол 2024 онд моторын багтаамж 3500 см³-ээс бага, дунд болон жижиг оврын суудлын автомашины импорт өндөр байв. Суудлын авто машины импорт нэмэгдэж, аймаг, сумдын тэмдэглэлт ойн арга хэмжээний тоо өссөнтэй холбоотойгоор авто бензиний импорт 464 сая ам.долларт хүрч, 15.9 хувиар өслөө.

64. Өргөн хэрэглээний хүнсний бүтээгдэхүүний импорт нэмэгдлээ. Өрхийн бодит орлого сүүлийн 5 улирал дараалан өсөж, өрхийн хэрэглээ нэмэгдсэнээр хүнсний бүтээгдэхүүний импорт 840 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс

24.7 хувиар өслөө. Мөн гурилын үнийн өсөлтийг бууруулж, нийлүүлэлтийг нэмэгдүүлэх хүрээнд улаан буудайн гурилын импортод хязгаар тогтоохгүй байж, 2024 оны 5 дугаар сарын 1-ний өдрөөс гаалийн албан татвараас чөлөөлөхөөр шийдвэрлэсэнтэй холбоотойгоор гурилын импорт 38.0 мянган тоннд хүрч өмнөх оны мөн үеэс 9 дахин нэмэгдлээ.

65. Ипотекийн зээлийн эх үүсвэр нэмэгдэж, цементийн гаалийн албан татварыг бууруулснаар барилгын материалын импорт өслөө. Барилгын салбарын үйлдвэрлэл 2024 оны 3 дугаар улирлын байдлаар 7.8 хувиар өссөн ба барилгын материалын импорт 1,028 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 17.2 хувиар өслөө. Хуримтлалын сангаас 0.5 их наяд төгрөгийг ипотекийн хөнгөлөлттэй зээлийн хөтөлбөрт оруулж, ипотекийн зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 1.8 их наяд төгрөгөөр өссөнөөр орон сууцны эрэлт өсөж, барилгын материалын импортыг нэмэгдүүллээ.

Барилгын үнийн хөөргөдлөөс сэргийлэх хүрээнд цементийн импортод хугацаа, хэмжээний хязгаарлалт тогтоохгүй байхаар шийдвэрлэж, Засгийн газрын 2024 оны 188 дугаар тогтоолоор 2024 оны 10 дугаар сарын 1-ний өдөр хүртэл цементийн гаалийн албан татварыг 20 хувиас 5 хувь болгож бууруулснаар цементийн импорт 86 мянган тоннд хүрч, өмнөх оны мөн үеэс 12 хувиар өссөн байна. 2024 оны төсвийн тухай хуульд тусгагдсан төслүүдийн бүтээн байгуулалт болон ипотекийн зээл олголтын нөлөөгөөр оны сүүлийн улиралд барилгын материалын импортын өсөлт хадгалагдахаар байна.


66. Замын-Үүд боомтын ачаа тээврийн хүчин чадлыг нэмэгдүүлж, ажлын цагийн горимд өөрчлөлт оруулснаар импортын барааны урсгал нэмэгдлээ. Замын-Үүд боомтоор нийт импортын бараа бүтээгдэхүүний 50 орчим хувь нь нэвтэрч байна. Монгол Улсын Засгийн газраас Замын-Үүд-Эрээн автозамын боомтыг 2024 оны 4 сарын 1-нээс 9 дүгээр сарын 30-ны өдрийг хүртэл 24 цагаар ажиллуулахаар шийдвэрлэсэн. Ийнхүү цагийн горимд өөрчлөлт орсноор Замын-Үүд боомтын ачаа тээврийн цогцолбороор 2023 оны 4 дүгээр сараас 8 дугаар сарын хооронд 93.8 мянган тээврийн хэрэгсэл улсын хил нэвтэрч байсан бол 2024 оны мөн үед 44 хувиар их буюу нийт 135.3 мянган тээврийн хэрэгсэл улсын хил нэвтэрсэн байна. Эдийн засгийн идэвхжил өндөр байгаа энэ үед нийлүүлэлтийн тасралтгүй байдлыг хангах нь бараа бүтээгдэхүүний үнийг тогтвортой байлгахад чухал хүчин зүйл юм.

67. Худалдааны гол түнш орнуудын бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлт саарснаар импортын барааны зардал бага түвшинд байв. Импортын дүн өмнөх оны мөн үеэс 1.9 тэрбум ам.доллараар өссөний 85 орчим хувийг тоо хэмжээ, 15 орчим хувийг үнийн өсөлт бүрдүүлсэн байна

(Зураг 4.2). Худалдааны гол түнш орнуудын үнийн өсөлт саарснаар импортын барааны үнийн өсөлт бага түвшинд байв. Тухайлбал, манай улсын нийт импортын 40 хувийг бүрдүүлж буй БНХАУ-ын инфляц 2024 оны эхний 3 улиралд дунджаар 0.3 хувь байв. Харин нийт импортын 25 хувийг бүрдүүлж буй ОХУ-ын инфляц 2024 оны эхний 3 улиралд дунджаар 8.3 хувь байв. Гэвч тус улсаас импортолж буй бүтээгдэхүүний 70 хувийг нефтийн бүтээгдэхүүн бүрдүүлж байгаа ба үүний 21 нэгж хувийг АИ-92 автобензин, 45 нэгж хувийг дизелийн түлш бүрдүүлж байна. ОХУ-ын Роснефть

компанитай 2022 онд байгуулсан хэлэлцээрийн дагуу АИ-92 шатахууныг тогтвортой үнээр худалдан авч байгаа бөгөөд ОХУ-ны дизелийн түлшний үнэ буурч байгаа нь импортын барааны үнийн өсөлт бага байхад нөлөөллөө. Түүнчлэн нийт импортын 10 хувийг бүрдүүлж буй Япон улсаас автомашин, түүний сэлбэг давамгайлсан бараа бүтээгдэхүүн худалдан авч байгаа бөгөөд Япон иений ам.доллартой харьцах ханш 1990 оноос хойших түүхэн доод түвшинд хүрч буурснаар тус улсаас худалдан авч буй барааны зардлыг буурууллаа.

Зураг 4.2. Импорт



ТӨЛБӨРИЙН ТЭНЦЭЛ


68. Барааны импортын өсөлтийн нөлөөгөөр урсгал дансны алдагдал тэллээ. Барааны экспорт 2024 оны эхний 3 улиралд өмнөх оны мөн үеэс 7 хувиар өссөн ч импорт 29 хувиар өссөнөөр урсгал дансны алдагдал 1.4 тэрбум ам.долларт буюу жилийн дүнгээр ДНБ-ий -7.2 хувьд хүрч буурлаа.

69. Ачаа тээврийн үйлчилгээний зардал буурсан нь үйлчилгээний дансны алдагдлын өсөлт саарахад эергээр нөлөөллөө. Засгийн газраас авч хэрэгжүүлж буй ашигт малтмалыг хил үнээр борлуулах, экспортын тээврийн үйл ажиллагааны зохион байгуулалтыг сайжруулах, үр ашгийг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээний үр дүнд ачаа тээврийн үйлчилгээний зардал 2024 оны эхний 3 улирлын байдлаар өмнөх оны мөн үеэс 20 хувиар буурсан эерэг үзүүлэлттэй байна. Ачаа тээврийн зардал буурсан нь өмнөх оны мөн үед 21 хувьд хүрсэн үйлчилгээний дансны алдагдлын өсөлт 2024 оны эхний 3 улиралд 8 хувьд хүрч буурахад нөлөөллөө.

70. Аяллын үйлчилгээний алдагдлын өсөлт өндөр байна. Энэ оны эхний 9 сарын байдлаар аяллын үйлчилгээний зардал өмнөх оноос 34 хувиар буюу 0.3 тэрбум ам.доллараар өссөн ч орлого ердөө 55 сая ам.доллараар нэмэгдлээ. Зардал өсөхөд гадаадад хувийн журмаар болон жуулчлалын зорилгоор зорчсон иргэдийн тоо өмнөх оны мөн үеэс 24 хувиар буюу 221 мянгаар нэмэгдсэн, гадаадад суралцагчдын сургалтын төлбөр өмнөх оны мөн үеэс 22 хувиар өссөн нь нөлөөллөө. Нөгөө талаас улсын хилээр орсон гадаад жуулчдын тоо өмнөх оны мөн үеэс 22 хувиар буюу 107 мянгаар өссөн хэдий ч аялал жуулчлалын үйлчилгээний орлогын өсөлт 12 хувьд хадгалагдлаа.

71. Шууд хөрөнгө оруулалт болон шинэ бондууд санхүүгийн дансны ашиг нэмэгдэхэд нөлөөллөө. Монгол Улсад орсон шууд хөрөнгө оруулалт 2024 оны эхний 3 улиралд 2.9 тэрбум ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 27 хувиар буюу 0.6 тэрбум ам.доллараар өслөө. Улсын

Зураг 4.3. Урсгал данс, санхүүгийн данс, төгрөгийн ханш



бүртгэлийн ерөнхий газрын статистикаар бүртгэлтэй гадаадын хөрөнгө оруулалттай компанийн тоо 2024 оны 9 дүгээр сарын байдлаар 349 болж, өмнөх оны мөн үеэс 2.3 дахин нэмэгдсэн байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад уул уурхайн салбарын шууд хөрөнгө оруулалт 0.6 тэрбум ам.доллаароор өссөн бол худалдаа, тээвэр, санхүүгийн салбарын хөрөнгө оруулалт нийт 84 сая ам.доллаароор буурлаа. Түүнчлэн, "МИК ОССК" ХХК, Монгол Улсын Хөгжлийн Банк, Голомт банк зэрэг байгууллагууд олон улсын зах зээлд шинэ бондууд гаргаснаар 2024 оны эхний 3 улирлын байдлаар санхүүгийн дансны ашиг өмнөх оны мөн үеэс 1.1 тэрбум ам.доллаароор нэмэгдлээ.


72. Гадаад валютын нөөцийн өсөлтийн хурд саарч, төгрөгийн нэрлэсэн үйлчилж буй ханш суларлаа. Энэ оны эхний улирлын эцэст жилийн 53 хувийн өсөлттэй байсан гадаад валютын нөөц 2024 оны 3 дугаар улирлын эцэст 4.7 тэрбум ам.доллар болж, жилийн өсөлт 13 хувьд хүрч саарлаа. Монголбанк энэ оны 2 дугаар улиралд нийт 0.6 тэрбум ам.долларын своп хэлцлийн эргэн төлөлтийг хийсний зэрэгцээ дуудлага худалдаагаар нийт 4.6 тэрбум ам.долларыг зах зээлд нийлүүлээ. Төгрөгийн ам.доллартой харьцах нэрлэсэн ханш 2024 оны 3 дугаар улирлын эцэст 3,381 төгрөг болж, өмнөх улирлын эцэс орчимд хадгалагдсан ч 2023 оны 5 дугаар сараас хойш чангараад байсан худалдааны түнш орнуудын валютаар жигнэсэн төгрөгийн нэрлэсэн ханшийн индекс 2024 оны 9 дүгээр сард өмнөх оны мөн үеэс 0.8 хувиар суларлаа. Харин дотоод үнийн өсөлт өндөр

байснаар бодит ханш 2024 оны 9 дүгээр сард өмнөх оны мөн үеэс 2.2 хувиар чангарлаа.

73. Хөрөнгө оруулалт нэмэгдэж, хадгаламжийн өсөлт саарснаар урсгал дансны тэнцэл буурлаа. Урсгал дансны тэнцлийг тухайн улсын нийт хадгаламж болон хөрөнгө оруулалтын зөрүүгээр мөн тайлбарладаг. Өнгөрсөн 2023 оны эцэст ДНБ-ий 0.6 хувь хүртэл сайжраад байсан урсгал дансны тэнцэл 2024 оны 3 дугаар улирлын байдлаар -7.2 хувь болж буурахад засгийн газрын хэрэглээ өсөж, хадгаламж буурахын зэрэгцээ хувийн секторын болон засгийн газрын хөрөнгө оруулалтын хэрэгцээ нэмэгдсэн нь нөлөөллөө.

74. Гадаад хөрөнгө оруулалтын позиц сул хэвээр байна. Гадаад улсад байршиж буй Монгол Улсын эзэмшлийн санхүүгийн хөрөнгө болон Монгол Улс бусад улсад төлөх үүрэг бүхий өр төлбөрийн зөрүүг харуулдаг гадаад хөрөнгө оруулалтын цэвэр позиц 2024 оны 3 дугаар улирлын эцэст -42.9 тэрбум ам.доллар буюу ДНБ-ий -184 хувьтай тэнцэж байна. Монгол улсад байршиж буй гадаад улсын эзэмшлийн санхүүгийн хөрөнгийн дүн 51.6 тэрбум ам.долларт хүрч, гадаад улсад байршиж буй Монгол Улсын эзэмшлийн санхүүгийн хөрөнгөөс 5.9 дахин их байна. Цаашид урсгал дансны алдагдлыг бууруулж, гадаад валютын нөөцийг зузаатгах замаар цэвэр позицыг сайжруулж, гадаад шокт өртөх эмзэг байдлыг бууруулах шаардлагатай.

Зураг 4.4. Урсгал данс ба гадаад хөрөнгө оруулалтын цэвэр позиц



75. Нийт гадаад өрийн үлдэгдлийн дүн өссөн ч ДНБ-д эзлэх хувь буурлаа. Монгол Улсын нийт гадаад өрийн үлдэгдэл 2024 оны 3 дугаар улирлын эцэст 35.6 тэрбум ам.доллар болж, өмнөх оны мөн үеэс 2.4 тэрбум ам.доллараар буюу 7.2 хувиар өслөө. Харин ДНБ-ий өсөлттэй холбоотойгоор ДНБ-д харьцуулсан гадаад өрийн хэмжээ 153 хувь болж, өмнөх оны мөн үеэс 21.7 нэгж хувиар буурсан байна.


76. Гадаад валютын нөөц тогтворжсон нь төв банк своп хэлцлийн өрийг бууруулах боломжийг бий болгов. 2022 онд 2.8 тэрбум ам.долларт хүрч буураад байсан гадаад валютын нөөц 2024 оны эхний улиралд 5.2 тэрбум ам.долларт хүрч нэмэгдсэнээр Монголбанк 2024 оны 2 дугаар улиралд Хятадын Ардын Банктай байгуулсан своп хэлцлийн 4.5 тэрбум юанийн эргэн төлөлтийг гүйцэтгэх боломжийг бүрдүүллээ. Улмаар төв банкны гадаад өр өмнөх оны мөн үеэс 813 сая ам.доллараар

буюу 42 хувиар буурч, тус своп хэлцлийн ашиглалтын үлдэгдэл 6.0 тэрбум юань болж буурлаа.

77. Хувийн хэвшлийн гадаад санхүүжилт нэмэгдлээ. Хувийн хэвшлийн гадаад өрийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 2.9 тэрбум ам.доллараар өссөний 83 хувийг шууд хөрөнгө оруулалттай компанийн зээллэг бүрдүүлсэн бөгөөд бусад төрлийн санхүүжилтийг харвал банкнуудын бондын үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 3 дахин, зээлийн үлдэгдэл 12 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байгаа нь хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдийн гадаад санхүүжилтийн эх үүсвэр нэмэгдсэнийг харуулж байна.

78. Манай улсын гадаад өрийн дийлэнхийг шууд хөрөнгө оруулалт болон зээл бүрдүүлж байна. Нийт гадаад өрийн үлдэгдлийн 47 хувь буюу 16.7 тэрбум ам.доллар нь шууд хөрөнгө оруулалттай компанийн өглөг, 39 хувь буюу 13.7 тэрбум ам.доллар

Зураг 4.5. Гадаад өр



нь зээл байна. Зээлийн үлдэгдлийн 54 хувийн Засгийн газар болон төв банк, 46 хувийг хувийн хэвшил бүрдүүлж байна. Цаашид макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангаж, зээлжих зэрэглэлийг сайжруулах замаар гадаад санхүүжилтийн эх үүсвэрийг нэмэгдүүлж, өртгийг бууруулах шаардлагатай.

79. Гадаад өрийн динамик дунд хугацаанд харьцангуй тогтвортой байгаа ч ханш, урсгал дансны тэнцлийн шокуудад эмзэг байна. Суурь


төсөөллөөр экспорт болон ДНБ-ий өсөлтийн эерэг нөлөөгөөр ДНБ-д харьцуулсан гадаад өрийн хэмжээ дунд хугацаанд тогтвортой буурахаар байна. Гэсэн хэдий ч ДНБ-д харьцуулсан гадаад өрийн хэмжээ ханшийн өөрчлөлт, урсгал дансны тэнцлийн шокуудад эмзэг байна. Суурь төсөөлөлтэй харьцуулахад гадаад өр болон ДНБ-ий харьцаа урсгал дансны үндсэн тэнцэл 1 стандарт хазайлтаар буурахад 12.3 нэгж хувиар, төгрөгийн ханш 10 хувиар сулрахад 15.2 нэгж хувиар тус тус өсөхөөр байна.

Зураг 4.7. Гадаад өрийн тогтвортой байдал

ГАДААД ӨР												
(өөрөөр тэмдэглээгүй бол ДНБ-д эзлэх хувиар)												
	Гүйцэтгэл						Төсөөлөл					Өр тогтворжуулах урсгал дансны үндсэн тэнцэл
	2018	2019	2020	2021	2022	2023	2024	2025	2026	2027	2028	
Гадаад өр: Суурь төсөөлөл	217.9	216.1	243.1	221.1	194.4	170.1	157.5	150.0	154.9	154.2	156.2	-2.5
Гадаад өрийн өөрчлөлт	-21.5	-1.7	26.9	-21.9	-26.7	-24.3	-12.5	-7.5	4.8	-0.6	2.0	
Өр үүсгэх урсгалууд	-20.9	-8.6	14.9	-25.3	-11.5	-32.4	-16.4	-13.2	-2.9	-11.2	-4.7	
Урсгал дансны алдагдал, хүүгийн төлбөрийг хассанаар	7.7	5.5	-4.9	5.6	4.9	-10.9	-1.4	-3.3	-6.1	-7.1	-2.1	
Өрийн бус хөрөнгийн цэвэр орох урсгал (-)	-6.8	-8.1	-4.6	-7.7	-0.9	-1.4	-1.8	-1.2	-1.0	-1.0	-1.5	
Өрийн автомат динамик 1/	-21.8	-6.0	24.4	-23.2	-15.6	-20.1	-13.3	-8.7	4.1	-3.1	-1.0	
Нэрлэсэн хүүгийн түвшний нөлөө	9.0	9.7	10.0	8.2	8.5	10.3	10.6	7.9	7.5	6.8	5.8	
Бодит ДНБ-ий өсөлтийн нөлөө	-16.2	-11.3	10.5	-3.5	-9.9	-12.2	-8.2	-10.5	-9.5	-9.4	-9.6	
Үнэ, валютын ханшийн өөрчлөлтийн нөлөө	-14.7	-4.5	3.9	-27.9	-14.2	-18.2	-15.6	-6.2	6.1	-0.5	2.7	
Бусад	-0.6	6.9	12.1	3.4	-15.2	8.1	3.9	5.7	7.8	10.5	6.6	
Гадаад өр-экспорт харьцаа (хувь)	374.5	364.8	423.3	377.7	303.4	223.0	223.7	207.5	194.3	188.3	192.7	
Гадаад өр: Гол хувьсагчид түүхэн дундаж түвшинд байх үед 2/							171.5	175.3	181.2	190.4	195.0	-4.5
						түүхэн стандарт дундаж хазайлт						
	Бодит ДНБ-ий өсөлт (хувь)	7.7	5.6	-4.6	1.6	5.0	7.4	4.0	3.9			
	Нэрлэсэн гадаад хүү (хувь)	4.3	4.8	4.3	3.9	4.3	6.3	4.6	0.6			
	Экспортын өсөлт (ам.доллараарх, хувь)	12.8	9.7	-9.1	17.1	22.8	41.1	14.5	17.6			
	Импортын өсөлт (ам.доллараарх, хувь)	37.5	3.1	-20.6	26.1	30.9	11.8	7.0	21.9			
	Урсгал дансны тэнцэл, хүүгийн төлбөр хассанаар	-7.7	-5.5	4.9	-5.6	-4.9	10.9	-1.4	6.2			
	Өрийн бус хөрөнгийн цэвэр орох урсгал	6.8	8.1	4.6	7.7	0.9	1.4	3.2	4.2			

1/ДНБ, гадаад өрийн хүү, ханш зэрэг үзүүлэлтүүдийн өөрчлөлтөөс шалтгаалах гадаад өрийн хэлбэлзэл
2/Гол хувьсагчид буюу урсгал дансны үндсэн тэнцэл, өрийн бус хөрөнгийн цэвэр орох урсгал, бодит ДНБ-ий жилийн өөрчлөлт, ДНБ-ий дефлятор, нэрлэсэн гадаад хүүний үзүүлэлтүүд сүүлийн 10 жилийн түүхэн дундажтай тэнцүү байхаар тооцов.


1. Суурь болон түүхэн дундаж хувилбар



2. Хүүгийн шок




3. ДНБ-ий өсөлтийн шок




4. Урсгал дансны үндсэн тэнцлийн шок



5. Хавсарсан шок
(хүү, урсгал данс, ДНБ-ий өсөлт)



6. Ханшийн шок



Эх сурвалж: ЭЗХЯ-ны тооцоолол
Тэмдэглэл: Түүхэн дундаж, стандарт хазайлтыг сүүлийн 10 жилийн үзүүлэлтээр тооцов. Урсгал данс, ДНБ-ий өсөлтийн шокийг 1 стандарт хазайлтаар, хүүгийн шокийг суурь түвшнээс 1 нэгж хувиар өсөхөөр, ханшийн шокийг 10 хувийн сулралтаар 2025-2026 оны хувьд тус тус тооцов.

БҮЛЭГ 5

ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСАГ

- 5.1 Дэлхийн эдийн засгийн нөхцөл байдал
- 5.2 Түүхий эдийн зах зээлийн хандлага
- 5.3 Олон улсад 2024 онд зарлагдсан индексүүд

5. ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСАГ

ТОЙМ

Дэлхийн эдийн засагт үйлчилгээний салбарын идэвхжил хадгалагдаж байгаа бол хөгжингүй орнуудад аж үйлдвэрийн салбарын идэвхжил сул хэвээр байна. Инфляцын түвшин буурсантай холбоотойгоор томоохон эдийн засгууд бодлогын хүүгээ буурууллаа. БНХАУ-ын эдийн засгийн өсөлтийн хурд 2024 оны 3 дугаар улиралд саарч, тус улсын засгийн газрын зорилтот түвшнээс бага байна.

ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

80. Дэлхийн эдийн засагт үйлчилгээний салбарын тэлэлт хэвээр хадгалагдаж, хөгжингүй орнуудад аж үйлдвэрийн салбарын идэвхжил сул хэвээр байна. Эдийн засгийн богино хугацааны төлөвийг илэрхийлэх дэлхийн худалдан авалтын менежерүүдийн индекс (PMI) хөгжингүй болон хөгжиж буй орнуудад үйлчилгээний салбарын идэвхжил өндөр байгааг, харин хөгжингүй орнуудын хувьд аж үйлдвэрлэлийн салбар сэргээгүй байгааг харуулж байна. Тухайлбал, үйлчилгээний салбарын PMI индекс 2023 оноос хойш тэлэлтийг илэрхийлэх босго утга 50-аас их хэвээр байгаа бол хөгжингүй орнуудын аж үйлдвэрлэлийн PMI индекс 2022 оны 10 дугаар сараас хойш босго утга 50-аас бага хэвээр байна.

81. Томоохон эдийн засгууд бодлогын хүүгээ буурууллаа. Инфляц болон хөдөлмөрийн зах зээлийн төлөвийг харгалзан Холбооны нөөцийн банк бодлогын хүүг цар тахлаас хойш эхний удаа 2024 оны 9 дүгээр сард 0.5 нэгж хувиар буурууллаа. Түүнчлэн, өнгөрсөн 6 дугаар сард бодлогын хүүгээ бууруулсан Европын төв банк 2024 оны 9 дүгээр сард хүүг дахин 0.25 нэгж хувиар буурууллаа. Ийнхүү томоохон эдийн засгууд бодлогын хүүгээ бууруулсан


Зураг 5.1. Дэлхийн эдийн засаг

нь дэлхийн санхүүгийн нөхцөл цаашид үргэлжлэн сулрах хүлээлтийг нэмэгдүүлж байна.

82. БНХАУ-ын эдийн засгийн өсөлт саарав. БНХАУ-ын үл хөдлөх хөрөнгийн салбарын уналт үргэлжилж, дотоод эрэлтийн сэргэлт сул байснаар 2024 оны эхний 3 улирлын эдийн засгийн өсөлт 4.8 хувьд хүрч саарлаа. Гэсэн хэдий ч манай улсын экспортын эрэлтэд чухал нөлөөтэй хойд бүсийн эдийн засгийн өсөлт нийт эдийн засгийн өсөлтөөс өндөр байна. Тус улсын Засгийн газраас 2024 оны өсөлтийг зорилтот түвшин 5.0 хувьд хүргэх бодлогын хүрээнд энэ оны 9 дүгээр сарын байдлаар бодлогын хүүг бууруулах, засгийн газрын болон орон нутгийн тусгай бондыг эрчимжүүлж, үл хөдлөх салбарыг дэмжих арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж байна.


83. Евро бүсийн эдийн засгийн өсөлт хүлээлтээс давав. Евро бүсийн эдийн засаг 2024 оны 3 дугаар улиралд хүлээлтээс өндөр буюу 0.4 хувиар өссөн нь сүүлийн 2 жилийн хамгийн өндөр өсөлт боллоо. Бүсийн хамгийн том эдийн засаг ХБНГУ-ын эдийн засаг 0.2 хувиар өсөж, хямралаас зайлсхийж, Франц болон Испани улсуудын өсөлт төсөөллөөс өндөр байсан нь бүсийн өсөлтийг дэмжлээ.

1. PMI индекс (индекс)




Эх сурвалж: S&P Global PMI, Блүүмберг
Тэмдэглэл: Индексийн 50-аас их (бага) утга нь тэлэлтийг (агшилтыг) илэрхийлнэ.

2. Бодлогын хүүгийн хүлээлт (хувь)



Эх сурвалж: Блүүмберг терминал

3. БНХАУ-ын эдийн засгийн өсөлт (хувь)



Эх сурвалж: Блүүмберг терминал

ТҮҮХИЙ ЭДИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ХАНДЛАГА

84. Лондоны металлын бирж дэх цэвэр зэсийн дундаж үнэ 2024 оны 3 дугаар улиралд 9,208 ам.доллар/тонн болж, өмнөх оны эцсээс 12.7 хувиар өссөн байна. Томоохон зэсийн уурхайнууд олборлолтоо бууруулж богино хугацаанд нийлүүлэлтийн тогтворгүй байдал бий болсноор зэсийн үнэ өсөхөд голлон нөлөөллөө.

85. Зүүн хойд Хятадын 62 хувийн агууламжтай төмрийн баяжмалын дундаж үнэ 2024 оны 3 дугаар улиралд 105 ам.доллар/тонн болж, өмнөх оны эцсээс 22 хувиар буурсан байна. Австрали, Бразил зэрэг улсуудын нийлүүлэлт нэмэгдсэн, БНХАУ-ын үл хөдлөх хөрөнгийн салбар сэргэж чадахгүй байгаа зэрэг нь төмрийн баяжмалын үнэ буурахад голлон нөлөөллөө.

86. Сингапурын бирж дэх Австралийн сайн чанарын коксжих нүүрсний дундаж үнэ 2024 оны 3 дугаар улиралд 212 ам.доллар/тонн болж, өмнөх оны эцсээс 36.6 хувиар буурсан байна. Саатаад байсан нийлүүлэлт тогтворжсон ч БНХАУ-ын Австрали улсаас худалдан авах коксжих нүүрсний хэмжээ цар тахлын өмнөх түвшинд хүрч сэргэж чадахгүй байгаа нь үнэ буурахад голлон нөлөөллөө.

87. Брент төрлийн газрын тосны дундаж үнэ 2024 оны 3 дугаар улиралд 75 ам.доллар/баррель болж, өмнөх оны эцсээс 2.9 буурсан байна. ОПЕК-ийн гишүүн орнууд газрын тосны нийлүүлэлтээ нэмэгдүүлэхээ зарласан нь газрын тосны үнэ буурахад голлон нөлөөллөө.

Зураг 5.2. Түүхий эдийн олон улсын зах зээл дэх үнэ

1. Лондоны металлын бирж дэх цэвэр зэсийн гүйцэтгэл (\$/тонн)



2. Зүүн хойд БНХАУ дахь 62 хувийн агууламжтай төмрийн баяжмалын гүйцэтгэл (\$/тонн)



3. Сингапурын бирж дэх Австралийн сайн чанарын коксжих нүүрсний гүйцэтгэл (\$/тонн)



4. Брент газрын тосны гүйцэтгэл (\$/баррель)



Эх сурвалж: Блүүмберг

ОЛОН УЛСАД 2024 ОНД ЗАРЛАГДСАН ИНДЕКСҮҮД

88. Дэлхийн засаглалын үзүүлэлтүүд: Авлигын хяналт, зохицуулалтын чанар, улс төрийн тогтвортой байдлын үзүүлэлтүүд дээшилснээр манай улсын Засаглалын үзүүлэлтийг ахиуллаа.

2024 оны 3 дугаар улирлын байдлаар Дэлхийн банкнаас эрхлэн гаргадаг Засаглалын үзүүлэлтүүд⁶ шинэчлэгдэн зарлагдаад байна. Тус үзүүлэлтээр нийт 213 улсыг хамруулан үнэлснээс Монгол Улс 2024 онд -0.08 оноогоор 111 дүгээр байрт эрэмбэлэгдсэн нь өмнөх оны үзүүлэлтээс 0.11 оноогоор өсөж, 2 байраар ахижээ.

Манай улсын үнэлгээг үзүүлэлтээр нь задалбал дараах байдалтай байна (Хүснэгт 3).

Хүснэгт 3. Дэлхийн засаглалын үзүүлэлтийн Монгол Улсын оноо, эрэмбэ

Бүлэг	2023		2024	
	Оноо	Байр	Оноо	Байр
Хууль дээдлэх ёс	-0.19	#116	-0.18▼	#120▼
Засгийн газрын үр ашиг	-0.42	#139	-0.47▼	#141▼
Зохицуулалтын чанар	-0.27	#123	-0.18▲	#116▲
Авлигын хяналт	-0.56	#143	-0.49▲	#138▲
Иргэдийн дуу хоолой ба оролцоо	0.26	#92	0.25▼	#98▼
Улс төрийн тогтвортой байдал	0.53	#79	0.59▲	#71▲
Нэгдсэн индекс	-0.15	#113	-0.08▲	#111▲

Хүснэгтээс харвал Хууль дээдлэх ёсны үзүүлэлтийн үнэлгээ өмнөх оны түвшнээс буурч 4 байраар ухарсан байна. Үүнд хууль эрх зүйн тогтолцоо сул, шүүхийн үйл ажиллагааны чанар олон улстай харьцуулахад доогуур байгаа нь нөлөөлжээ. Мөн Засгийн газрын үр ашгийн үзүүлэлтээр 0.05 оноо буурч, 2 байраар ухарсан байна. Үүнд бодлогын хэрэгжилт хангалтгүй байгаа нь нөлөөлсөн гэж дүгнэжээ. Түүнчлэн Иргэдийн дуу хоолой ба оролцоо буюу иргэдийн

төрд итгэх итгэлийг илэрхийлдэг үзүүлэлт өмнөх оноос 0.01 оноогоор буурч 6 байраар ухарсан үзүүлэлтэй байна.

Харин төрийн үйл ажиллагааг цахимжуулах цогц арга хэмжээний үр дүнд төрийн байгууллагын үр ашиг, ил тод байдал нэмэгдсэн нь Зохицуулалтын чанарын үзүүлэлтийн эрэмбийг 7 байр, Авлигын хяналтын үзүүлэлтийн эрэмбийг 5 байр ахиулж индексийн үнэлгээг сайжруулжээ. Мөн улс төрийн тогтвортой байдал сайжирснаар тус үзүүлэлтийн үнэлгээ 0.06 оноогоор өсөж, 8 байр ахисан байна. Засаглалын үзүүлэлтийн Монгол Улсын үнэлгээг 11 тайлан, судалгааны үр дүнг ашиглан тооцсон бөгөөд 2024 оны тайланг 2022-2023 оны гүйцэтгэлд суурилж тооцсон байна.

Олон улсад 2024 онд Европын Холбооны орнууд, Шинэ Зеланд, Сингапур, Австрали зэрэг орнууд засаглалын чанараар тэргүүлээ. Засаглалын үзүүлэлтээр амжилттай яваа улс орнуудад ил тод, хариуцлагатай засаглалыг бэхжүүлж, улс төрийн хувьд тогтвортой, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, хууль дээдлэх ёсны үзүүлэлт өндөртэй байна. Харин Өмнөд Судан, Сири, Сомали, Йемен засаглалын үзүүлэлтээр сүүл мушгиж байна. Эдгээр улсуудад дотоодын зэвсэгт мөргөлдөөн, иргэний дайн зэрэг улс төрийн байдал тогтворгүй, иргэдийн эрх чөлөө хязгаарлагдмал, авлига, хээл хахууль өндөр, засаглалын чанар, үр ашиг, төрд итгэх итгэл сул зэрэг шалтгааны улмаас жагсаалтын сүүлд эрэмбэлэгджээ.

89. Дэлхийн эдийн засгийн эрх чөлөөт байдлын индекс: 2022 оны инфляцын өсөлт нь Дэлхийн эдийн засгийн эрх чөлөөт байдлын индекс дэх Монгол Улсын үнэлгээг бууруулахад голчлон нөлөөллөө.

Фрэйзер институтээс⁷ жил бүр тооцоолон гаргадаг Дэлхийн эдийн засгийн эрх чөлөөт байдлын

⁶ Засаглалын үзүүлэлтийг улс орнуудын Хууль дээдлэх ёс, Засгийн газрын үр ашиг, Зохицуулалтын чанар, Авлигын хяналт, Иргэдийн дуу хоолой ба оролцоо болон Улс төрийн тогтвортой байдал гэсэн 6 үзүүлэлтийг тус бүрд нь тооцдог. Индексийн дундаж үнэлгээг 0-ээр тооцож тархаан -2.5-2.5 онооны хооронд үнэлдэг бөгөөд индекс 2.5-д ойртох тусам засаглал сайн, -2.5-д дөхөх тусам засаглал сул гэж үздэг.

⁷ Fraser Institute

индексээр⁸ Монгол Улс 2024 онд дэлхийн 165 улсаас 69 дүгээрт эрэмбэлэгдэж өмнөх оноос 2 байр ухарлаа.

Манай улсын үнэлгээг бүлгээр задалбал дараах байдалтай байна (Хүснэгт 4).

Хүснэгт 4. Дэлхийн эдийн засгийн эрх чөлөөт байдлын индексийн Монгол Улсын оноо, эрэмбэ

Бүлэг	2023		2024	
	Оноо	Байр	Оноо	Байр
Засгийн газрын хэмжээ	6.55	#82	6.59▲	#84▼
Хуулийн тогтолцоо ба өмчийн эрх	6.05	#49	6.05	#49
Мөнгөний үнэ цэнэ	8.74	#80	7.51▼	#88▼
Олон улсын худалдааны эрх чөлөө	7.09	#73	7.29▲	#80▼
Зохицуулалт	6.76	#70	6.85▲	#58▲
Нэгдсэн индекс	7.04	#67	6.86▼	#69▼

Манай улсын хувьд 2024 онд Дэлхийн эдийн засгийн эрх чөлөөт байдлын индексээр 6.86 оноо авсан нь дэлхийн дунджаас 0.2 оноогоор дээгүүр байна. Үзүүлэлтээр задлан харвал Засгийн газрын хэрэглээний нийт хэрэглээнд эзлэх хувь буурснаар Засгийн газрын хэрэглээний үзүүлэлтийн үнэлгээ 0.23 оноогоор нэмэгдэж, 1 байр ахисан нь Засгийн газрын хэмжээ бүлгийн оноог 0.04 оноогоор нэмэгдэхэд хүргэжээ. Монгол Улсад визгүй зорчих улсын тоо нэмэгдэж тус үзүүлэлтийн үнэлгээ 3.8 оноогоор сайжирсан нь Олон улсын худалдааны эрх чөлөөний бүлгийн үнэлгээг 0.2 оноогоор нэмэгдүүллээ. Түүнчлэн төсвийн алдагдал буурсан, Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга хэрэгжиж эхэлснээр хөдөлмөрийн харилцаан дахь зохицуулалт сайжирсан, олон улсын тайлангуудад шинжээчид төрийн шударга байдал, хүнд суртлын үнэлгээг ахиулж дүгнэсэн нь Зохицуулалт бүлгийн үнэлгээг 0.09 оноогоор, эрэмбийг 12 байраар ахиуллаа. Эдгээр үзүүлэлтүүдээр оноо ахисан боловч бусад улс орнуудын үнэлгээ мөн сайжирсан тул манай улсын эрэмбэ төдийлөн сайжраагүй байна. Дэлхийн эдийн засгийн эрх чөлөөт байдлын индексийг тооцохдоо 5 бүлгийн 25 дэд бүлэг үзүүлэлтээр бүлэг бүрд ижил жин өгч тооцдог. 25 дэд бүлэг нь мөн цааш шалгуур үзүүлэлтүүдэд задардаг бөгөөд дэд бүлэг бүр харилцан адилгүй шалгуур үзүүлэлтүүдээр хэмжигддэг. Тухайлбал Мөнгөний үнэ цэнэ бүлэг зөвхөн 4 тоон үзүүлэлтээр хэмжигдэх бол Зохицуулалт бүлэг тоон болон чанарын 17 үзүүлэлтээр хэмжигдэж байна. Иймд хамгийн бага шалгуур үзүүлэлт бүхий дэд бүлэг индексийн үнэлгээнд хамгийн их нөлөө үзүүлж байгаа гэж тооцвол Инфляцын түвшин дангаараа индексийн

⁸ Дэлхийн эдийн засгийн эрх чөлөөт байдлын индексийг улс орнуудын Засгийн газрын хэмжээ, Хуулийн тогтолцоо ба өмчийн эрх, Мөнгөний үнэ цэнэ, Олон улсын худалдааны эрх чөлөө, Зохицуулалт гэсэн 5 бүлэг, 25 дэд бүлгийн хүрээнд нэгтгэн тооцдог байна. Нийт 0-10 онооны хооронд үнэлдэг бөгөөд индекс 10-д ойртох тусам эдийн засгийн эрх чөлөөт байдал өндөр, 0-д дөхөх тусам эдийн засгийн эрх чөлөөт байдал сул гэж үздэг.

үнэлгээний 10 хувийг бүрдүүлж байна. Өөрөөр хэлбэл, инфляцын үзүүлэлтийг сайжруулснаар Дэлхийн эдийн засгийн эрх чөлөөт байдлын индексийн үнэлгээг хамгийн хялбараар сайжруулах боломжтой гэсэн үг юм.

Инфляцын үзүүлэлтийг инфляцын сүүлийн 5 жилийн стандарт хазайлт болон инфляцын жилийн дундаж түвшнээр хэмждэг бөгөөд үзүүлэлт бага гарах тусам сайн, өндөр гарах тусам муу гэж үнэлэгддэг.

Гэтэл Монгол Улсын инфляцын жилийн дундаж түвшин 2022 он (Дэлхийн эдийн засгийн эрх чөлөөт байдлын индексийн 2024 оны үр дүн нь 2022 оны тоо, мэдээлэлд суурилж тооцогдсон)-д 15.2 хувьд хүрч нэмэгдсэн нь индексийн үнэлгээг бууруулах гол шалтгаан болсон байна. Харин 2023-2024 онд инфляцын түвшин буурсан тул уг үзүүлэлтийн ирэх жилүүдийн үр дүн сайжрах төлөвтэй байна (Зураг 5.3).



Дэлхийн эдийн засгийн эрх чөлөөт байдлын индексийг олон улсын түвшинд авч үзвэл, 2024 онд дэлхийн дундаж оноо КОВИД-19 цар тахлын өмнөх 2019 оны түвшнээс 0.24 оноогоор буурч 6.56 оноонд хүрсэн нь цар тахлын нөлөөгөөр төрийн оролцоо нэмэгдэж, эдийн засгийн эрх чөлөөт байдал буурсантай холбоотой гэж дүгнэжээ. Тус индексээр Хонконг (БНХАУ-ын Засаг захиргааны онцгой бүс), Сингапур, Швейцар, Шинэ Зеланд, АНУ, Дани зэрэг улсууд тэргүүлж байна. Эдийн засгийн эрх чөлөөний үзүүлэлтээр тэргүүлж буй улс орнуудад төрийн зохицуулалт бага, чөлөөт зах зээлийн тогтолцоо бүрдсэн байна. Тухайлбал, Хонконг (БНХАУ-ын Засаг захиргааны онцгой бүс) болон Сингапур нь өрсөлдөх чадвартай эдийн засагтай, бизнесийн чухал төвүүд бөгөөд мөнгөний бодлого тогтвортой, төрийн оролцоо бага байдаг нь бизнес эрхлэх, хөрөнгө оруулалт хийх таатай орчныг

бүрдүүлдэг байна. Харин Венесуэл, Зимбабве, Судан, Сири, Алжир, Мьянмар улсууд эдийн засгийн эрх чөлөөний үзүүлэлтээр жагсаалтын төгсгөлд эрэмбэлэгджээ. Эдгээр улсуудад авлига, хээл хахууль өндөр, хуулийн хэрэгжилт сул, зохицуулалтын чанар муу, төрийн оролцоо өндөр байна. Үүний зэрэгцээ, тухайн улсуудын эдийн засгийн тогтворгүй байдал,

инфляц болон валютын ханшийн хэлбэлзэл нь иргэдийн амьжиргааны түвшинд сөргөөр нөлөөлж, дотоодын эдийн засгийн өсөлтөд саад болдог байна. Мөн эдгээр улсуудад дотоодын болон олон улсын худалдаанд оролцох хязгаарлалт, хамгаалалтын арга хэмжээ их байгаа нь эдийн засгийн эрх чөлөөг бууруулж байна.

БҮЛЭГ 6
ЭРСДЭЛ

ЭРСДЭЛ

НЭГ. ЗУД Өвөлжилт, хаваржилт хүндэрсний улмаас бойжуулсан төлийн тоо 2023 оны эцэст 28 хувиар буурч, том малын зүй бус хорогдол 2024 оны эхний 3 улирлын байдлаар 8.1 сая толгойд хүрсэн нь ирэх онуудад махны нийлүүлэлт буурч, хүнсний инфляц өсөх, мөн хөдөө аж ахуйн үйлдвэрлэл багасаж, малчдын амьжиргаа муудаж, хэрэглээ хумигдах, цаашлаад эдийн засаг дахь хөрөнгийн хуримтлалд сөрөг нөлөө үзүүлж, өсөлтийг сааруулах эрсдэлтэй байна.

ХОЁР. ТҮҮХИЙ ЭДИЙН ҮНИЙН ХЭЛБЭЛЗЭЛ

Дэлхийн эдийн засгийн тодорхой бус байдлаас шалтгаалсан эрэлт, нийлүүлэлтийн тогтворгүй байдал манай улсын экспортын голлох бүтээгдэхүүнүүдийн гадаад зах зээл дээрх үнийн хэлбэлзлийг нэмэгдүүлж, манай улсын экспортын орлогод сөргөөр нөлөөлж болзошгүй байна. Мөн түүхий эдийн дэлхийн зах зээлд өндөр нөлөө бүхий БНХАУ-ын үл хөдлөх хөрөнгийн салбарын уналт үргэлжилж, тус улсын эдийн засгийн өсөлт хүлээлтээс бага байх нь манай улсын экспортын түүхий эдийн эрэлт, үнийг бууруулах замаар экспортын орлогод сөргөөр нөлөөлж болзошгүй.

ГУРАВ. ГЕОПОЛИТИКИЙН ТОГТВОРГҮЙ БАЙДАЛ

ОХУ-Украины нөхцөл байдал даамжрах,

Газын зурвас, Израйл орчмын бүс нутгийн мөргөлдөөн хурцдах, Улаан тэнгист халдлага үргэлжлэх зэрэг эрсдэлүүд авто бензин, улаан буудай, хүнс, эрчим хүч зэрэг манай улсын импортын голлох бараа бүтээгдэхүүний үнийг өсгөж болзошгүй байна.

ДӨРӨВ. ЭРЧИМ ХҮЧНИЙ ТАСРАЛТГҮЙ, НАЙДВАРТАЙ БАЙДАЛ

Эрчим хүч нь эдийн засаг, нийгмийн тогтвортой байдлыг хангах суурь хүчин зүйл боловч манай улс дотоодын цахилгаан хүчний хэрэглээний 20 орчим хувийг импортолж байна. Манай улсын эрчим хүчний станцуудын насжилт өндөр, түгээлтийн шугам, тоног төхөөрөмжийн дийлэнх нь хуучирч, элэгдсэн эрсдэлтэй нөхцөлд ажиллаж байгаа бөгөөд эрчим хүчний нийлүүлэлт тасалдах нь бодит салбаруудын үйл ажиллагаа, нийт эдийн засгийн бүтээмжийг хязгаарлах эрсдэлтэй.

ТАВ. НИЙЛҮҮЛЭЛТИЙН ТАСАЛДАЛ

Монгол улсын нийт импортын 80 орчим хувь нь Тяньжин боомтоор дамжин Замын-Үүд боомтоор орж ирдэг. Тяньжин боомтоос өдөрт гарах галт тэрэгний тоо буурсантай холбоотойгоор тус боомт дээрх чингэлгийн тоо өссөн нь импортын бараа, бүтээгдэхүүний нийлүүлэлтийн хугацааг уртасгаж, үнийг өсөх эрсдэлийг дагуулж байна.

ХАВСРАЛТ

МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

	2020	2021	2022	2023	2024Q1	2024Q2	2024Q3
БОДИТ СЕКТОР							
Нэрлэсэн ДНБ (тэрбум төгрөгөөр)	37,453	43,555	53,852	70,442	16,663	37,420	56,188
Бодит ДНБ өсөлт - үйлдвэрлэл (хувиар)	-4.6	1.6	5.0	7.4	7.9	5.6	5.0
Бодит ДНБ өсөлт - эцсийн ашиглалт (хувиар)	-4.4	1.6	5.0	7.2	8.0	5.7	4.9
Дотоод эрэлтийн оролцоо (нэгж хувиар)	-12.6	17.6	11.4	5.4	32.5	27.7	25.7
Бараа, үйлчилгээний экспортын оролцоо (нэгж хувиар)	-2.7	-7.5	13.9	18.0	-7.2	-1.5	-2.1
Бараа, үйлчилгээний импортын оролцоо (нэгж хувиар)	11.0	-8.5	-20.3	-16.2	-17.3	-20.5	-18.8
Бодит ДНБ-ий өсөлт дэх оролцоо (нэгж хувиар)							
Эцсийн хэрэглээ	3.6	-2.3	6.5	7.0	22.0	21.5	16.9
Өрхийн хэрэглээ	1.3	-4.0	5.1	6.3	12.7	12.1	10.0
Төрийн байгууллагын хэрэглээ	2.2	1.7	1.4	0.7	9.3	9.3	6.9
Хөрөнгийн нийт хуримтлал	-16.2	19.9	4.9	-1.6	10.5	6.2	8.8
Цэвэр экспорт	8.2	-16.0	-6.4	1.8	-24.5	-21.9	-20.8
ҮНИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД							
Инфляц (ХҮИ-ийн өсөлт, хугацааны эцсээр, хувиар)	2.3	13.8	13.2	7.9	7.0	5.1	6.7
Зэсийн үнэ* (\$/тонн)	6,178	9,315	8,815	8,479	8,443	9,094	9,132
Алтын үнэ* (\$/трой. унци)	1,772	1,799	1,802	1,943	2,074	2,206	2,688
Газрын тосны үнэ* (\$/баррел, Brent)	51	60	78	76	77	79	78
ДНБ дефлятор (хувиар)	3.7	14.4	17.7	21.8	10.5	14.4	13.0
(тэрбум төгрөгөөр)							
НЭГДСЭН ТӨСВИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД							
Нийт орлого ба тусламжийн дүн	10,444	14,306	18,522	24,387	7,673	14,947	22,350
Тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн	9,464	12,711	17,127	23,295	7,322	14,199	21,290
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	13,904	15,630	18,160	22,509	5,695	12,911	19,822
Нийт тэнцэл	-3,460	-1,324	362	1,878	1,978	2,036	2,528
Нийт үндсэн тэнцэл	-2,521	-488	1,160	3,028	2,380	2,631	3,486
Тэнцвэржүүлсэн тэнцэл	-4,440	-2,919	-1,033	786	1,627	1,287	1,469
ЗГ-ын нийт өр (нэрлэсэн, ДНБ-д эзлэх хувиар)	75.5	62.6	60.5	44.7	37.7	38.3	38.9
ЗГ-ын нийт өр (нэрлэсэн, тэрбум төгрөгөөр)	27,899	26,918	31,965	30,774	29,772	30,247	30,814
МӨНГӨНИЙ СЕКТОР							
M2 мөнгөний өсөлт (хувиар)	16.2	13.8	6.5	26.8	20.9	31.9	25.9
Нөөц мөнгөний өсөлт (хувиар)	-12.7	6.5	39.9	7.4	11.7	29.6	5.8
Мөнгөний эргэлтийн хурд (нэгжээр)	1.5	1.6	1.8	1.9	2.0	1.9	1.9
Мөнгөний үржүүлэгч (нэгжээр)	5.4	5.8	4.4	5.2	6.1	5.5	6.3
Зээлийн өсөлт** (хувиар)	-4.0	18.5	7.5	22.7	22.3	27.3	31.3
(сая ам.доллаароор)							
ТӨЛБӨРИЙН ТЭНЦЭЛ							
Төлбөрийн тэнцэл	787	-222	-727	1,457	373	-57	-251
Урсгал дансны тэнцэл	-675	-2,108	-2,304	121	-251	-583	-1,368
ГВУН	4,534	4,366	3,400	4,921	5,250	4,839	0
сарын бараа, үйлчилгээний импортын хүрэлцээ	7.4	5.7	3.4	4.4	4.4	3.9	3.6
Гадаад валютын ханш							
Валютын ханш USD/MNT (дунджаар)	2,813	2,849	3,140	3,466	3,392	3,386	3,384
Валютын ханш USD/MNT (хугацааны эцсээр)	2,850	2,849	3,445	3,411	3,376	3,381	3,381
Нэрлэсэн үйлчилж буй ханшийн индекс (дунджаар)	43.0	41.3	38.8	37.6	39.4	39.6	39.5
Бодит үйлчилж буй ханшийн индекс (дунджаар)	102.9	102.8	105.7	111.1	117.6	119.2	119.4

*Bloomberg Terminal

**Ипотекийн зээлээр баталгаажсан бондыг оруулсан дүн

Хүснэгт 6. Бодит секторын үзүүлэлтүүд

БОДИТ СЕКТОРЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД							
	2020	2021	2022	2023	2024Q1	2024Q2	2024Q3
Нэрлэсэн ДНБ (үйлдвэрлэлийн аргаар)	37,453	43,555	53,852	70,442	16,663	37,420	56,188
Бодит ДНБ (үйлдвэрлэлийн аргаар)	26,655	27,092	28,455	30,567	6,077	14,419	22,829
(өсөлт, хувиар)							
Бодит ДНБ-ий өсөлт	-4.6	1.6	5.0	7.4	7.9	5.6	5.0
Уул уурхайн	-9.9	0.8	-15.3	23.4	13.3	15.4	11.4
Уул уурхайн бус	-3.7	1.8	8.2	5.4	7.0	4.2	4.0
Хөдөө аж ахуй	5.8	-5.5	12.0	-8.9	-24.8	-26.7	-25.0
Уул уурхай	-9.9	0.8	-15.3	23.4	13.3	15.4	11.4
Боловсруулах аж үйлдвэр	3.4	-0.9	6.1	5.1	4.9	6.3	0.1
Цахилгаан дулаан	1.8	9.4	3.3	5.0	7.7	5.3	5.2
Барилга	-3.2	-22.8	8.2	3.1	27.7	19.5	7.8
Бөөний болон жижиглэн худалдаа	-12.5	5.8	10.1	6.8	6.0	6.8	7.9
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	-18.2	-7.3	9.2	39.6	26.9	24.7	15.7
Мэдээлэл, холбоо	5.2	20.7	6.6	17.0	27.5	17.4	14.4
Бусад үйл ажиллагаа	-2.6	3.8	5.4	5.8	3.4	7.1	8.6
Цэвэр татвар	-9.4	12.2	11.5	6.6	13.1	15.0	14.6
Дефлятор	3.7	14.4	17.7	21.8	10.5	14.4	13.0
(нэгж хувиар)							
ДНБ-ий өсөлт дэх салбаруудын оролцоо							
Хөдөө аж ахуй	0.8	-0.8	1.7	-1.3	-1.0	-3.9	-3.5
Уул уурхай	-1.4	0.1	-2.1	2.6	1.9	1.8	1.4
Боловсруулах аж үйлдвэр	0.3	-0.1	0.5	0.4	0.3	0.4	0.0
Цахилгаан дулаан	0.0	0.2	0.1	0.1	0.3	0.2	0.1
Барилга	-0.1	-0.9	0.2	0.1	0.2	0.3	0.1
Бөөний болон жижиглэн худалдаа	-1.4	0.6	1.1	0.8	0.7	0.7	0.9
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	-1.0	-0.3	0.4	1.8	1.3	1.0	0.9
Мэдээлэл, холбоо	0.1	0.5	0.2	0.5	0.9	0.6	0.5
Бусад үйл ажиллагаа	-0.7	1.1	1.6	1.7	1.2	2.1	2.4
Цэвэр татвар	-1.1	1.3	1.4	0.8	2.1	2.3	2.1
(тэрбум төгрөгөөр)							
Нэрлэсэн ДНБ (эцсийн ашиглалтын аргаар)	37,883	44,703	54,878	71,202	17,473	38,022	57,818
Анхдагч орлого	-3,526	-6,359	-5,072	-7,738	-1,693	-4,465	-6,811
Үндэсний нийт орлого	34,357	38,344	49,806	63,463	15,780	33,558	51,007
Хоёрдогч орлого	769	1,223	1,363	1,378	592	857	1,493
Үндэсний нийт цэвэр орлого	35,126	39,566	51,169	64,842	16,372	34,414	52,501
Нийт дотоод эрэлт	36,953	45,574	58,219	64,404	17,098	36,042	56,970
Үндэсний хадгаламж	6,556	9,985	15,747	24,317	4,001	8,357	12,971
Хөрөнгийн нийт хуримтлал	8,383	15,993	22,796	23,880	4,727	9,985	17,440

НЭГДСЭН ТӨСВИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД							
	2020	2021	2022	2023	2024Q1	2024Q2	2024Q3
(тэрбум төгрөгөөр)							
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	10,444	14,306	18,522	24,387	7,673	14,947	22,350
Ирээдүйн өв сан	914	967	0	416	284	528	694
Тогтворжуулалтын сан	66	628	1,395	676	67	221	366
ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	9,464	12,711	17,127	23,295	7,322	14,199	21,290
Татварын орлого	8,512	11,300	15,459	21,484	6,909	13,291	19,952
Орлогын албан татвар	2,227	3,326	3,827	5,703	2,557	4,266	6,402
Нийгмийн даатгалын орлого	1,586	2,286	3,038	3,951	920	2,105	3,322
Хөрөнгийн албан татвар	155	201	238	395	109	240	335
Нэмэгдсэн өртгийн албан татвар	2,209	2,838	3,946	4,777	1,286	2,777	4,313
Онцгой албан татвар	777	827	848	790	280	515	819
Тусгай зориулалтын орлого	17	17	19	22	6	13	19
Гаалийн албан татвар	741	939	1,256	1,465	352	813	1,315
Бусад татвар,төлбөр, хураамж	800	866	2,288	4,382	1,398	2,561	3,426
Татварын бус орлого	952	1,412	1,668	1,811	413	908	1,338
Нийтлэг татварын бус орлого	785	1,250	1,364	1,452	339	717	1,036
Хөрөнгийн орлого	1	2	4	8	1	2	5
Тусламжийн орлого	166	160	300	351	73	188	297
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	13,904	15,630	18,160	22,509	5,695	12,911	19,822
Урсгал зарлага	10,829	12,804	14,229	17,091	4,698	10,376	15,551
Цалин, хөлс	2,649	2,532	1,666	2,327	1,081	2,585	3,706
Бараа, үйлчилгээний бусад зардал	2,202	2,170	2,140	2,758	687	1,660	2,432
Татаас	375	454	537	580	134	367	649
Урсгал шилжүүлэг	4,663	6,813	9,088	10,276	2,394	5,170	7,807
Зээлийн үйлчилгээний төлбөр	939	836	798	1,150	402	595	958
Гадаад	776	681	694	1,054	395	582	943
Дотоод	163	155	104	96	6	13	15
Хөрөнгийн зардал ба цэвэр зээл	3,075	2,826	3,930	5,418	997	2,535	4,271
Хөрөнгийн зардал	3,034	2,982	3,803	5,188	843	2,296	3,967
Эргэж төлөгдөх цэвэр зээл	41	-156	127	229	154	239	304
НИЙТ ТЭНЦЭЛ	-3,460	-1,324	362	1,878	1,978	2,036	2,528
ҮНДСЭН ТЭНЦЭЛ	-2,521	-488	1,160	3,028	2,380	2,631	3,486
ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ТЭНЦЭЛ	-4,440	-2,919	-1,033	786	1,627	1,287	1,469

ТӨЛБӨРИЙН ТЭНЦЛИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

	2020	2021	2022	2023
	(ДНБ-д эзлэх хувиар)			
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	27.9	32.8	34.4	34.6
Ирээдүйн өв сан	2.4	2.2	0.0	0.6
Тогтворжуулалтын сан	0.2	1.4	2.6	1.0
ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	25.3	29.2	31.8	33.1
Татварын орлого	22.7	25.9	28.7	30.5
Орлогын албан татвар	5.9	7.6	7.1	8.1
Нийгмийн даатгалын орлого	4.2	5.2	5.6	5.6
Хөрөнгийн албан татвар	0.4	0.5	0.4	0.6
Нэмэгдсэн өртгийн албан татвар	5.9	6.5	7.3	6.8
Онцгой албан татвар	2.1	1.9	1.6	1.1
Тусгай зориулалтын орлого	0.0	0.0	0.0	0.0
Гаалийн албан татвар	2.0	2.2	2.3	2.1
Бусад татвар, төлбөр, хураамж	2.1	2.0	4.2	6.2
Татварын бус орлого	2.5	3.2	3.1	2.6
Нийтлэг татварын бус орлого	2.1	2.9	2.5	2.1
Хөрөнгийн орлого	0.0	0.0	0.0	0.0
Тусламжийн орлого	0.4	0.4	0.6	0.5
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	37.1	35.9	33.7	32.0
Урсгал зарлага	28.9	29.4	26.4	24.3
Цалин, хөлс	7.1	5.8	3.1	3.3
Бараа, үйлчилгээний бусад зардал	5.9	5.0	4.0	3.9
Татаас	1.0	1.0	1.0	0.8
Урсгал шилжүүлэг	12.5	15.6	16.9	14.6
Зээлийн үйлчилгээний төлбөр	2.5	1.9	1.5	1.6
Гадаад	2.1	1.6	1.3	1.5
Дотоод	0.4	0.4	0.2	0.1
Хөрөнгийн зардал ба цэвэр зээл	8.2	6.5	7.3	7.7
Хөрөнгийн зардал	8.1	6.8	7.1	7.4
Эргэж төлөгдөх цэвэр зээл	0.1	-0.4	0.2	0.3
НИЙТ ТЭНЦЭЛ	-9.2	-3.0	0.7	2.7
ҮНДСЭН ТЭНЦЭЛ	-6.7	-1.1	2.2	4.3
ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ТЭНЦЭЛ	-11.9	-6.7	-1.9	1.1

ТӨЛБӨРИЙН ТЭНЦЛИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД							
	2020	2021	2022	2023	2024Q1	2024Q2	2024Q3
	(сая ам.доллороор)						
I. УРСГАЛ ДАНС	-675	-2,108	-2,304	121	-251	-583	-1,368
Бараа	1,756	1,370	1,233	4,549	920	1,865	2,223
Экспорт Ф.О.Б (кредит)	6,991	8,136	9,854	13,914	3,431	7,443	11,064
Импорт Ф.О.Б (дебит)	5,235	6,766	8,622	9,366	2,511	5,578	8,841
Үйлчилгээ	-1,450	-1,675	-2,355	-2,592	-846	-1,383	-2,019
Кредит	655	814	1,135	1,587	275	615	1,190
Дебит	2,105	2,490	3,490	4,179	1,121	1,998	3,209
Анхдагч орлого	-1,253	-2,232	-1,615	-2,233	-499	-1,319	-2,012
Кредит	341	292	344	455	132	279	430
Дебит	1,595	2,524	1,959	2,687	631	1,598	2,442
Хоёрдогч орлого	273	429	434	398	175	253	441
II. ХӨРӨНГИЙН ДАНС	103	114	154	135	32	78	120
Кредит	105	116	166	149	36	87	130
Дебит	2	2	12	14	4	9	10
III. САНХҮҮГИЙН ДАНС: (зээлдүүлэг+/зээллэг-)	-1,504	-1,982	-1,644	-1,477	-857	-660	-1,307
Шууд хөрөнгө оруулалт (цэвэр)	-1,693	-2,060	-2,428	-2,172	-580	-1,464	-1,975
Багцын хөрөнгө оруулалт (цэвэр)	563	25	445	818	-16	-252	-277
Санхүүгийн үүсмэл хэрэгслүүд (цэвэр)	-6	-8	-11	-2	8	0	-8
Бусад хөрөнгө оруулалт (цэвэр)	-369	60	351	-121	-269	1,056	953
Үүнээс: Бэлэн мөнгө ба харилцах	278	245	298	354	-245	894	755
Зээл	-803	-501	67	-529	-86	-43	-157
Худалдааны зээл	156	413	-15	54	61	205	356
IV. Алдаа болон орхигдуулга	-146	-209	-222	-276	-265	-213	-310
Төлбөрийн тэнцлийн нийт дүн	787	-222	-727	1,457	373	-57	-251
V. Нөөц хөрөнгө	787	-222	-727	1,457	373	-57	-251
ГВУН	787	-225	-751	1,398	359	-96	-307
ОУВС-гийн зээл	0	-3	-24	-59	-14	-38	-56
Тусгай санхүүжилт	0	0	0	0	0	0	0
Нэмэлт үзүүлэлтүүд:							
Нэрлэсэн ДНБ (сая ам.доллараар)	13,314	15,286	17,150	20,325	4,912	11,052	16,603
Гадаад валютын албан нөөц (сая ам.доллараар)	4,534	4,366	3,400	4,921	5,250	4,839	4,663
Гадаад валютын албан нөөц (сарын импортоор)	7.4	5.7	3.4	4.4	4.4	3.9	3.6
Валютын ханш MNT/USD (дунджаар)	2,813	2,849	3,140	3,466	3,392	3,386	3,384
Валютын ханш MNT/USD (хугацааны эцсээр)	2,850	2,849	3,445	3,411	3,376	3,381	3,381

ТӨЛБӨРИЙН ТЭНЦЛИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

	2020	2021	2022	2023
	(ДНБ-д эзлэх хувиар)			
I. УРСГАЛ ДАНС	-5.1	-13.8	-13.4	0.6
Бараа	13.2	9.0	7.2	22.4
Экспорт Ф.О.Б (кредит)	52.5	53.2	57.5	68.5
Импорт Ф.О.Б (дебит)	39.3	44.3	50.3	46.1
Үйлчилгээ	-10.9	-11.0	-13.7	-12.8
Кредит	4.9	5.3	6.6	7.8
Дебит	15.8	16.3	20.4	20.6
Анхдагч орлого	-9.4	-14.6	-9.4	-11.0
Кредит	2.6	1.9	2.0	2.2
Дебит	12.0	16.5	11.4	13.2
Хоёрдогч орлого	2.1	2.8	2.5	2.0
II. ХӨРӨНГИЙН ДАНС	0.8	0.7	0.9	0.7
Кредит	0.8	0.8	1.0	0.7
Дебит	0.0	0.0	0.1	0.1
III. САНХҮҮГИЙН ДАНС: (зээлдүүлэг+/зээллэг-)	-11.3	-13.0	-9.6	-7.3
Шууд хөрөнгө оруулалт (цэвэр)	-12.7	-13.5	-14.2	-10.7
Багцын хөрөнгө оруулалт (цэвэр)	4.2	0.2	2.6	4.0
Санхүүгийн үүсмэл хэрэгслүүд (цэвэр)	0.0	0.0	-0.1	0.0
Бусад хөрөнгө оруулалт (цэвэр)	-2.8	0.4	2.0	-0.6
Үүнээс: Бэлэн мөнгө ба харилцах	2.1	1.6	1.7	1.7
Зээл	-6.0	-3.3	0.4	-2.6
Худалдааны зээл	1.2	2.7	-0.1	0.3
IV. Алдаа болон орхигдуулга	-1.1	-1.4	-1.3	-1.4
<i>Төлбөрийн тэнцлийн нийт дүн</i>	5.9	-1.4	-4.2	7.2
V. Нөөц хөрөнгө	5.9	-1.4	-4.2	7.2
ГВУН	5.9	-1.5	-4.4	6.9
ОУВС-гийн зээл	0.0	0.0	-0.1	-0.3
Тусгай санхүүжилт	0.0	0.0	0.0	0.0
Нэмэлт үзүүлэлтүүд:				
Нэрлэсэн ДНБ (сая ам.доллараар)	13,314	15,286	17,150	20,325
Гадаад валютын албан нөөц (сая ам.доллараар)	4,534	4,366	3,400	4,921
Гадаад валютын албан нөөц (сарын импортоор)	7.4	5.7	3.4	4.4
Валютын ханш MNT/USD (дунджаар)	2,813	2,849	3,140	3,466
Валютын ханш MNT/USD (хугацааны эцсээр)	2,850	2,849	3,445	3,411

МӨНГӨНИЙ ҮЗҮҮЛЭЛТҮҮД							
	2020	2021	2022	2023	2024Q1	2024Q2	2024Q3
(тэрбум төгрөгөөр)							
Гадаад цэвэр актив	5,816	3,806	2,492	8,959	9,775	9,865	8,437
Дотоод цэвэр актив	18,664	24,057	27,173	28,665	27,625	31,603	33,366
Дотоодын цэвэр зээл	19,136	24,298	25,648	29,106	28,477	32,296	34,091
Бусад цэвэр зүйлс	-472	-241	1,525	-441	-852	-694	-726
M2 мөнгө	24,481	27,863	29,665	37,624	37,400	41,467	41,803
Хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө	753	847	831	906	827	1,040	961
Харилцах болон хадгаламж	23,728	27,016	28,834	36,719	36,573	40,428	40,841
(өсөлт, хувиар)							
Жилийн өсөлт							
M2 мөнгө	16.2	13.8	6.5	26.8	20.9	31.9	25.9
Гадаад цэвэр актив	80.9	-34.6	-34.5	259.6	148.4	146.7	27.7
Дотоод цэвэр актив	4.6	28.9	13.0	5.5	2.3	15.1	25.4
Дотоодын цэвэр зээл	2.3	27.0	5.6	13.5	12.4	20.2	28.2
ЗГ-аас авах авлага	-29.6	-49.8	107.6	91.3	57.9	53.9	30.1
Бусад салбараас авах авлага	-2.2	19.2	9.9	19.8	18.5	24.8	28.5
Улсын байгууллагаас авах авлага	1,492.6	25.0	-5.0	-16.7	-8.6	13.2	0.2
Хувийн сектороос авах авлага	-7.2	18.8	10.8	21.7	19.8	25.2	29.6
(нэгж хувиар)							
M2 мөнгөний өсөлт дэх оролцоо							
M2 мөнгө	16.2	13.8	6.5	26.8	20.9	31.9	25.9
Гадаад цэвэр актив	12.4	-8.2	-4.7	21.8	18.9	18.7	5.5
Дотоод цэвэр актив	3.9	22.0	11.2	5.0	2.0	13.2	20.4
Нэмэлт үзүүлэлтүүд:							
Мөнгөний эргэлтийн хурд	1.5	1.6	1.8	1.9	2.0	1.9	1.9
Нэрлэсэн ДНБ-ий өсөлт (хувиар)	-1.0	16.3	23.6	30.8	19.3	20.8	18.6
Инфляц (ХҮИ-ийн өсөлт, хугацааны эцсээр, хувиар)	2.3	13.8	13.2	7.9	7.0	5.1	6.7